



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН
2024 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН**

АУДИТЫН КОД: БӨА-2025/02/НА-СТА-НТГ

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгт, хавсралтын товъёог	4
ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	5-6
БҮЛЭГ 1. ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ	7
1.1 Аймгийн төсвийн орлогыг төсвийн бодлого, бүсчилсэн хөгжлийн бодлого, жилийн хөгжлийн бодлоготой нийцүүлэн төлөвлөсөн байдал	7-8
1.1.1 Орон нутгийн төсвийн нийт орлогын төлөвлөлт	8-10
1.1.2 Орон нутгийн төсвийн суурь орлогын төлөвлөлт	10-13
1.2 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ТӨЛӨВЛӨЛТ	13
1.2.1 Орон нутгийн төсвийн нийт зарлагын төлөвлөлт	14-18
БҮЛЭГ 2. ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	19
2.1. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ	19
2.1.1 Орон нутгийн төсвийн нийт орлогын гүйцэтгэл.....	19-20
2.1.2 Орон нутгийн суурь орлогын гүйцэтгэл	20-23
2.2 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ	23
2.2.1 Төсвийн зарлагын гүйцэтгэл	23-33
2.2.2 Нэмэлт санхүүжилтийн зарцуулалт	33-34
БҮЛЭГ 3. ХӨТӨЛБӨР, ХҮРЭХ ҮР ДҮН, ЗОРИЛТОТ ТҮВШНИЙ ХЭРЭГЖИЛТ	34
3.1 ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүн, зорилтот түвшин	34-35
БҮЛЭГ 4. ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬ, ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР	35
4.1 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	35
4.2 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	35-36
ДҮГНЭЛТ:	37
ЗӨВЛӨМЖ:	38
ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ	39
ХАВСРАЛТ:	40-43

Хүснэгтийн товъёог

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт№1	Улсын төсвөөс олгох дэмжлэг, орлогын шилжүүлгийн төлөвлөлт	9
Хүснэгт №2	Орон нутгийн нийт орлогын төлөвлөгөө	9
Хүснэгт №3	Суурь орлогын төлөвлөлт /өмнөх онтой харьцуулахад/	11
Хүснэгт №4	Суурь орлогын төлөвлөлт/Орлогын төрлөөр/	11-12
Хүснэгт №5	Малын тоо, толгойн албан татварын төлөвлөлт	12-13
Хүснэгт №6	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчин хамгаалах, нөхөн сэргээх зардалд төлөвлөсөн байдал	13
Хүснэгт№7	Орон нутгийн зарлагын төлөвлөгөө	14-15
Хүснэгт№8	Орон нутгийн төсвийн суурь орлого, зарлагын төлөвлөлт	15-16
Хүснэгт№9	Орон нутгийн төсвийн нийт орлогын гүйцэтгэл	19
Хүснэгт №10	Орон нутгийн суурь орлогын гүйцэтгэл	20-21
Хүснэгт№11	Орон нутгийн суурь орлогын гүйцэтгэл / аймаг, сумаар/	21-22
Хүснэгт №12	Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл үр дүнгийн шагнал олгосон хувь	22-23
Хүснэгт №13	Төсвийн нийт зарлагын гүйцэтгэл	23-24
Хүснэгт №14	Төсвийн нийт зарлагын гүйцэтгэлийг байгууллагаар харуулбал	25
Хүснэгт №15	Аймгийн төсвийн шууд байгууллагуудын төсвийн гүйцэтгэлийг байгууллагаар харуулбал	26
Хүснэгт №16	Аймгийн ерөнхий дансны зарцуулалт	27
Хүснэгт №17	Худалдан авах ажиллагааны судалгаа	31
Хүснэгт №18	БГБНАҮТХ-ийн зардлын судалгаа	32
Хүснэгт №19	Бараа үйлчилгээний бусад зардлын судалгаа	32
Хүснэгт №20	ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын орон тоо, цалингийн судалгаа	33

Хавсралтын товъёог

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт №1	ТЕЗ-ийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	41-43
Хавсралт №2	ТЕЗ-ийн нэмэлт санхүүжилтийн тайлан	44-45

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудит хийх үндэслэл бүрэн эрх:

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4 дэх заалт, Монгол Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны “Аудитын сэдэв батлах тухай” 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны “Санхүүгийн тайлангийн аудит хийх байгууллагын жагсаалт, аудит хийх хэлбэр батлах тухай А/52-1, “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/108 дугаар тушаал, Баян-Өлгий аймаг дахь төрийн аудитын газрын 2024 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн дарга, тэргүүлэх аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны орон нутгийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлд аудит хийнэ.

Аудитын зорилт:

Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны орон нутгийн нэгдсэн төсвийн төлөвлөлт үндэслэлтэй эсэх, гүйцэтгэлийг үнэн зөв нэгтгэж тайлагнасан эсэхийг шалгаж, дүгнэлт гаргах, аудитын мөрөөр илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, санал зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв. Энэхүү зорилтыг хэрэгжүүлэхийн тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг хэрэгжүүлнэ. Үүнд:

Аймгийн ТЕЗ-ийн 2024 оны орон нутгийн төсвийг бодитой төлөвлөж, бүрдүүлсэн эсэх

Аймгийн ТЕЗ-ийн 2024 оны орон нутгийн батлагдсан төсвийг зориулалтын дагуу, үр дүнтэй зарцуулсан эсэх

Аймгийн ТЕЗ-ийн 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүн, зорилтот түвшинд хүрсэн эсэх

Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан эсэх

Аудитын хамарсан хүрээ:

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан, аймаг, сумдын ИТХ-ын хуралдааны тогтоол, аймгийн Засаг даргын захирамж, аймгийн Татварын хэлтсийн аудитад хамрагдах хэсгийн татварын төлөвлөгөө, тайлан, Сангийн яамнаас Баян-Өлгий аймгийн 2024 оны аймгийн төсвийн суурь, орлого зарлагыг хянаж ирүүлсэн тооцоо болон бусад холбогдох материалд тулгуурлан аудитыг гүйцэтгэв.

Аудитын арга зүй:

Аудитыг АДБОУС 100, 300, 400, 3000, 4000-д нийцүүлэн боловсруулсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, МУЕА-ын 2021 оны А/71 тушаал “Заавар аргачлал батлах тухай” журмын аргачлалыг баримтлан аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс болон бусад холбогдох хэлтсүүдийн албан тушаалтнуудтай ярилцлага хийх, судалгаа, тоон мэдээлэл авах, нэгтгэх, тулган баталгаажуулах, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, асуудын шинжилгээ, горимын дагуу нотлох зүйл цуглуулан, аудитын дүгнэлт, зөвлөмжийг боловсруулав.

Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт:

Төсвийн тухай хууль, Төрийн аудитын тухай хууль, Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хууль, Улсын Их Хурлын 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн баталсан “Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хууль”, 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар оруулсан нэмэлт өөрчлөлт, Татварын багц хуулиуд, аймгийн ИТХ-ын “Төсөв батлах тухай” 2024 оны 221 тоот тогтоол, “Аймгийн 2024 орон нутгийн төсөвт тодотгол хийх тухай” 2024 оны 257, 262 дугаар тогтоолууд, аймгийн ТЕЗ-ийн 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн актуудыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа:

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл хянан удирдаж, аудитын менежер Х.Женисбек чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Д.Назгүл, аудитор Х.Еркебулан нарын бүрэлдэхүүнтэй аудитын баг 2024 оны 04 дүгээр сарын 01-ээс 04 дүгээр сарын 20-ыг хүртэл хугацаанд төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдсан мэдээлэл:

Аудитын ерөнхий зүйл, аудитын дүн, аудитын дүгнэлт, зөвлөмж, холбогдох байгууллагын санал, хавсралт гэсэн агуулгаар бичигдсэн. Аудитын нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

БҮЛЭГ 1. ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ

1. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨЛТ

1.1 Аймгийн төсвийн орлогыг төсвийн бодлого, бүсчилсэн хөгжлийн бодлого, жилийн хөгжлийн бодлоготой нийцүүлэн төлөвлөсөн байдал

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль, Улсын Их Хурал, Засгийн газраас 2024 онд баримталсан төсвийн бодлого, чиглэлийг орон нутгийн 2024 оны төсвийн төсөлд тусган боловсруулж аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулж, баталсан төсвийг хөгжлийн бодлоготой нийцүүлэн чиглэл болгон ажилласан байна.

Төсвийн орлогын талаар:

Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль болон Малын тоо толгойн албан татварын тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт орсонтой холбогдуулан иргэд, хуулийн этгээдэд эдгээр хуулийн нэмэлт, өөрчлөлтийг сурталчлан таниулах ажлыг харьяа татварын албатай хамтран зохион байгуулж, татварын орлогыг дайчлах зэргээр орон нутгийн төсвийн орлогын хэмжээг нэмэгдүүлж тодотгож төлөвлөсөн байна.

Аймаг, сумд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийг татварын удирдлагын нэгдсэн системд бүртгүүлэх ажлыг эрчимжүүлэх, төрийн байгууллагуудын мэдээллийн уялдаа холбоог сайжруулж, төсвийн орлогын бааз суурийг тэлэх, төсвийн орлогыг нэмэгдүүлэх, татварын ногдол, хуримтлагдсан татварын өр төлбөрийг барагдуулах, байгалийн нөөц ашиглах зөвшөөрөл олгохдоо зөвшөөрөл эзэмшигчийн талаар мэдээлэл бүртгэлийн санг үүсгэн баяжуулж, харьяалах татварын албанд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн талаарх мэдээллийг тухай бүр хүргүүлж ажилласан байна.

Усны нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх чиглэлээр сум, дүүргийн Засаг дарга, Усны газар, сав газрын захиргаа, төвлөрсөн ус хангамжийн байгууллага, татварын алба ус ашиглагчийн үйлдвэр, үйлчилгээнд ашигласан усны хэмжээг бодитоор тодорхойлон, төлбөрийн орлогыг орон нутгийн төсөвт бүрэн төвлөрүүлэхэд хамтран ажиллаж, дэмжлэг үзүүлэх талаар чиглэл баримталж ажиллажээ.

Төсвийн зарлагын талаар:

Засгийн газрын 2023 оны 312 дугаар тогтоолыг үндэслэн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд Худалдан авах ажиллагааны газар байгуулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохих журмын дагуу зохион байгуулахаар албан хаагчдыг орон тоо, цалингийн сан, эд хөрөнгийн хамт Орон нутгийн өмчийн газраас шилжүүлэн ажиллуулах арга хэмжээг аймгийн Засаг даргын батлагдсан орон тоо, төсөвт багтаан хэрэгжүүлэхээр 2024 оны төсөвт тусгаж батлуулсан байна.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд төрийн албан хаагчдын цалин хөлсийг 2024 оны 4 дүгээр сараас эхлэн нэмэгдүүлэхээр төлөвлөсний дагуу

нийтлэг төрийн үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалинг 20 хувиар, бусад төрийн албан хаагчдын үндсэн цалинг 10 хувиар нэмэгдүүлж төлөвлөсөн байна.

2024 оны төсөвт орон нутгийн нэмэгдлийг хөдөөгийн суманд үндсэн цалингийн 40 хувиар, харин аймгийн төвт ажиллаж байгаа төрийн албан хаагчдад үндсэн цалингийн 20 хувиар тооцож төлөвлөж баталсан байна.

Орон нутгийн нэмэгдлийн суурь хэмжээг тухайн орон нутгийн хөгжлийн бодлогын хүрээнд босоо болон хэвтээ удирдлагатай байгууллагын албан хаагчдад нэмэгдүүлж олгох асуудлыг аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн жилийн орон нутгийн төсөвтөө тусган шийдвэрлэж болно гэсний дагуу 2024 оны 4 дүгээр сараас 10 хувиар, 2024 оны 06 дугаар сараас 30 хувиар тооцож нэмэгдүүлж төлөвлөсөн байна.

Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 82 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох журам”-ын дагуу хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдад олгох мөнгөн урамшууллыг тооцож төлөвлөсөн байна.

Орон нутгийн суурь зардалд Тохижилт үйлчилгээний байгууллагын урсгал зардлыг 20 хувиар нэмэгдүүлэн төлөвлөсөн ба цалин хөлс, тогтмол зардал, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс, шатахууны зардлыг оруулж тооцсон тул холбогдох тариф болон гэрээг шинэчлэн мөрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.18-д заасан чиг үүргийн дагуу орон нутаг төсвийн төсөл боловсруулахдаа эрүүл мэнд, боловсрол, нийгэм, соёлын байгууллагуудын байгууллагуудын барилгын ашиглалтын болон их засварын зардлыг орон нутгийн төсөвтөө бүрэн тусган санхүүжүүлэхээр төлөвлөж ажилласан байна.

Аймгийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд нийт 18 салбар үр дүнг, ТЕЗ-ийн 25 үр дүнгийн үзүүлэлтээр тодорхойлсон 55 хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх 70 үндсэн үйл ажиллагааг төлөвлөсөн байна.

Аймгийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөө нь хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй нийцсэн байна.

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨЛТ

Орон нутгийн төсвийн нийт орлогын төлөвлөгөө өмнөх оны түвшнээс 33,737.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна

1.1.1 Орон нутгийн төсвийн нийт орлогын төлөвлөлт

УИХ-ын 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар Баян-Өлгий аймагт улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 25,670.8 сая төгрөгөөр, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 11,406.6 сая төгрөгөөр баталсан байна.

Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуульд 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар орсон өөрчлөлтөөр тус аймагт улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 3,590.2 сая төгрөгөөр бууруулж 22,080.6 сая төгрөгөөр, Орон нутгийн

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2024 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлгийг 542.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж 11,949.5 сая төгрөгөөр баталсан байна.

Хүснэгт №1 Улсын төсвөөс олгох дэмжлэг, орлогын шилжүүлгийн төлөвлөлт

Төгрөгөөр

Үзүүлэлт	МУ-ын 2024 оны Төсвийн тухай хууль, орсон өөрчлөлт				
	2023 он	2023.11.10		2024.08.30	
	1	2	3	/3-1/	/3-2/
Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	12,789.50	25,670.8	22,080.6	9,291.1	3,590.2
ОНХ-ийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлэг	10,073.80	11,406.6	11,949.5	1,875.7	542.9
Тусламж санхүүжилтийн орлогын нийт дүн	22,863.30	37,077.3	34,030.1	11,166.8	3,047.2

Эх сурвалж: Аудитын судалгаа

Өмнөх онтой харьцуулахад улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 9,291.1 сая төгрөгөөр, ОНХ-ийн нэгдсэн сангаас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлэг 1,875.7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны төсвийн төслийг Төсвийн тухай хуулийн 8.4.31-д заасан хугацаанд боловсруулж Сангийн яаманд хүргүүлсэн байна.

Сангийн яамны хянаж ирүүлсэн аймгийн нийт орлогын төсөв 55,430.0 сая төгрөг байна. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 221 дүгээр тогтоолоор орон нутгийн төсвийн нийт орлогыг Сангийн яамны хянаж ирүүлсэн дүнг 8,811.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 64,241.0 сая төгрөгөөр баталсан байна.

Хүснэгт №2 Орон нутгийн нийт орлогын төлөвлөгөө

сая төгрөгөөр

Үзүүлэлт	Сангийн яамны хянаж ирүүлсэн /2023.11.10/	Аймгийн ИТХ-ын 2023.12.04-ний №221 дугаар тогтоолоор анх баталсан	Аймгийн ИТХ-ын 2024.06.07-ны №257 дугаар тогтоол Тодотгол-1	Аймгийн ИТХ-ын 2024.09.24-ны №262 дугаар тогтоол Тодотгол-2	Сумын ИТХ-аар баталсан дүнг нэмсэн дүнгээр	Зөрүү
	1	2	4	5	6	/6-1/
Татварын орлого	16,696.60	24,786.50	31,333.60	34,191.10	36,229.90	19,533.30
Татварын бус орлого	1,656.00	2,377.10	3,474.30	3,488.80	3,595.80	1,939.80
Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	25,670.80	25,670.80	25,670.80	22,080.60	22,080.60	-3,590.20
ОНХ-ийн сангийн шилжүүлэг	11,406.60	11,406.60	11,406.60	11,949.50	11,949.50	542.90
Үндсэн үйл ажиллагааны орлого					1,724.10	1,724.10
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	0	0	1,869.70	1,869.70	5,199.10	5,199.10
Нийт орлогын дүн	55,430.00	64,241.00	73,755.00	73,579.70	80,779.00	25,349.00

Эх сурвалж: Аудитын судалгаа

Аймгийн ИТХ-ын “Аймгийн 2024 оны төсвийн тодотгол батлах тухай” 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 257 дугаар тогтоолоор татварын болон татварын бус орлогын төлөвлөгөөг 7,644.3 сая төгрөгөөр, урьд оны үлдэгдлээс санхүүжих дүнг 1,869.7 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж нийт орлого, эх үүсвэрийн төлөвлөгөөг 73,755.0 сая төгрөгөөр тодотгож баталсан байна.

Аймгийн ИТХ-ын “Аймгийн 2024 оны төсөвт тодотгол хийх тухай” 2024 оны 262 дугаар тогтоолоор татварын болон татварын бус орлогын төлөвлөгөөг 2,872.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 3,590.2 сая төгрөгөөр бууруулж, ОНХ-ийн сангаас олгох орлогын шилжүүлгийг 542.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж нийт орлого, эх үүсвэрийг 73,579.7 сая төгрөгөөр баталсан байна.

Сумуудын ИТХ-ын тогтоолоор нэмж баталсан дүнгээр аймгийн 2024 оны орлогын нийт төлөвлөгөө 80,779.0 сая төгрөг байна. Үүнээс: Орон нутгийн суурь орлого буюу татварын болон татварын бус орлогыг 39,825.7 сая төгрөгөөр, Орон нутгийн хөгжлийн сангийн шилжүүлгийг 11,949.5 сая төгрөгөөр, үндсэн үйл ажиллагааны орлогыг 1,724.1 сая төгрөгөөр, урьд оны үлдэгдлээс санхүүжих дүнг 5,199.1 сая төгрөгөөр төлөвлөж, 22,080.6 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авах төлөвлөгөөтэй байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогын 1,540.6 сая төгрөг нь сумуудын Хоршоог хөгжүүлэх сангийн орлогын төлөвлөгөө ба 183.5 сая төгрөг нь төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөө байна.

1.1.2 Орон нутгийн төсвийн суурь орлогын төлөвлөлт

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны төсвийн суурь орлогын төсвийн төслийг Сангийн яаманд 16,120.9 сая төгрөгөөр төлөвлөж хүргүүлснийг 18,352.6 сая төгрөгөөр хянаж ирүүлсэн байна.

Аймгийн ИТХ-ын 2023 оны “Аймгийн 2024 оны төсөв батлах тухай” 221 дүгээр тогтоолоор аймгийн орон нутгийн төсвийн суурь орлогыг Сангийн яамнаас хянасан дүнг 8,811.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 27,163.6 сая төгрөгөөр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2024 оны “Аймгийн 2024 оны орон нутгийн төсөвт тодотгол хийх тухай” 257 дугаар тогтоолоор аймгийн орон нутгийн төсвийн суурь орлогыг анх баталснаас 7,644.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж 34,807.9 сая төгрөгөөр тодотгож баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2024 оны “Аймгийн 2024 оны орон нутгийн төсөвт тодотгол хийх тухай” 262 дугаар тогтоолоор аймгийн орон нутгийн төсвийн суурь орлогыг өмнөх баталсныг 2,872.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 37,679.9 сая төгрөгөөр тодотгож баталсан байна.

Сумуудын ИТХ-ын тогтоолоор нэмэгдүүлж баталсныг оруулж тооцоход аймгийн 2024 оны суурь орлогын нийт төлөвлөгөө 39,825.8 сая төгрөг байна. Үүнээс 36,229.9 сая төгрөгийг татварын орлогоос, 3,595.9 сая төгрөгийг татварын бус орлогоос оруулахаар төлөвлөжээ.

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2024 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Сумууд орон нутгийн төсвийн орлогыг аймгийн ИТХ-аас баталсан дээр 3,870.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Үүнд: ХХОАТ-ыг 1,378.9 сая төгрөгөөр, малд ногдуулах албан татварыг 333.4 сая төгрөгөөр, бусад татвар, төлбөр хураамжийг 76.3 сая төгрөгөөр, газрын төлбөрийг 107.6 сая төгрөгөөр, байгалийн нөөц ашигласны төлбөрийг 142,6 сая төгрөгөөр, татварын бус орлогыг 107.1 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж баталсан байна.

Хүснэгт №3

Суурь орлогын төлөвлөлтийг өмнөх онтой харьцуулахад

сая төгрөгөөр

№	Үзүүлэлт	2023 он	2024 он	Зөрүү
1	Аймгийн суурь орлого	2,231.4	5,003.8	2,772.4
2	Сумуудын орлого	18,389.0	34,822.0	16,433.0
	Нийт орлого	20,620.4	39,825.8	19,205.4

Эх сурвалж: Аудитын судалгаа

Орон нутгийн төсвийн суурь орлогын төлөвлөгөөг өмнөх онтой харьцуулахад 19,205.4 сая төгрөгөөр нэмэгдсэн ба аймгийн төсөвт орох орлогын төлөвлөгөө 2,772.4 сая төгрөгөөр, сумуудын төсөвт орох орлогын төлөвлөгөө 16,433.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Орон нутгийн суурь орлогын төлөвлөгөөг орлогын нэр төрлөөр авч үзэхэд:

Хүснэгт №4 **Суурь орлогын төлөвлөлт/Орлогын төрлөөр/**

сая төгрөгөөр

Орлогын төрөл	Сангийн яамны хянасан суурь	Аймгийн ИТХ-ын 2023 оны 12.02-ны 221 дүгээр тогтоол	Аймгийн ИТХ-ын 2024 оны 257 дугаар тогтоол	Аймгийн ИТХ-ын 2024 оны 262 дугаар тогтоол	Сумуудын ИТХ-ын тогтоолоор баталсныг нэмсэн дүнгээр	Зөрүү	
		a	b	c		d	e
СУУРЬ ОРЛОГО	18,352.6	27,163.6	34,807.9	37,679.9	39,825.8	12,662.2	21,473.2
УРСГАЛ ОРЛОГО	18,352.6	27,163.6	34,807.9	37,679.9	39,825.8	12,662.2	21,473.2
ТАТВАРЫН ОРЛОГО	16,696.6	24,786.5	31,333.6	34,191.1	36,229.9	11,443.4	19,533.3
Орлогын албан татвар	13,074.0	20,535.1	27,082.1	28,475.1	29,854.0	9,318.9	16,780.0
ХАОАТатвар	13,074.0	20,535.1	27,082.1	28,475.1	29,854.0	9,318.9	16,780.0
Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татвар	12,500.0	20,000.0	23,020.0	23,120.0	24,248.3	4,248.3	11,748.33
Үйл ажиллагааны орлого	567.9	423.9	4,433.0	4,433.0	4,498.4	4,074.4	3,930.42
Хөрөнгийн орлого	955.0	1,010.1	1,010.1	1,703.1	1,889.5	879.4	934.51
Хөрөнгө борлуулсны орлогын албан татвар	251.1	301.1	301.1	901.1	901.7	600.7	650.66
ХХОАТатварын буцаан олголт	(1,200.0)	(1,200.0)	(1,682.0)	(1,682.0)	(1,683.9)	(483.9)	(483.88)
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	550.0	550.0	550.0	1,450.0	1,450.0	900.0	900.00
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	550.0	550.0	550.0	1,450.0	1,450.0	900.0	900.00
Хөрөнгийн татвар	1,290.0	1,290.0	1,290.0	1,290.0	1,623.4	333.4	333.4
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	480.0	480.0	480.0	480.0	480.0	-	-
Бууны албан татвар	60.0	60.0	60.0	60.0	60.0	-	-

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2024 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Малд ногдуулах албан татвар					333.4	333.4	333.42
АТӨЯХАТатвар	750.0	750.0	750.0	750.0	750.0	-	-
Бусад татвар	432.1	795.5	795.5	996.4	1,072.7	277.2	640.6
Улсын тэмдэгийн хураамж	362.1	452.5	452.5	653.4	679.3	226.8	317.18
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	55.0	225.0	225.0	225.0	246.4	21.4	191.44
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	15.0	118.0	118.0	118.0	117.0	(1.0)	102.00
Бусад татвар					30.0	30.0	30.00
Газрын төлбөр	373.0	373.0	373.0	373.0	480.6	107.6	107.6
Газрын төлбөр	373.0	373.0	373.0	373.0	480.6	107.6	107.58
Байгалийн нөөц ашигласны төлбөр	977.5	1,242.9	1,242.9	1,606.6	1,749.2	506.2	771.7
Ойн нөөц ашигласны төлбөр	52.5	52.5	52.5	52.5	52.2	(0.3)	(0.27)
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	900.0	1,165.5	1,165.5	1,529.1	1,670.6	505.1	770.55
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	25.0	25.0	25.0	25.0	26.4	1.4	1.40
II.Татварын бус орлого	1,656.0	2,377.1	3,474.3	3,488.8	3,595.8	1,218.8	1,939.9
Хүүгийн орлого	113.6	613.6	613.6	625.6		(613.6)	(113.60)
Торгуулийн орлого	1,500.0	1,500.0	1,500.0	1,500.0	2,230.7	730.7	730.70
Төсөвт газрын өөрийн орлого	42.4	263.5	263.5	183.5	183.5	(80.0)	141.09
Бусад нэр заагдаагүй орлого			1,097.2	1,179.7	1,181.7	1,181.7	1,181.70

Эх сурвалж: Сангийн яамны хянаж ирүүлсэн дүн болон аймаг, сумын ИТХ-ын тогтоолууд

Аймгийн ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 262 дугаар тогтоолоор төсөвт байгууллагын өөрийн орлогын 183.5 сая төгрөгийг давхардуулж илүү төлөвлөсөн. Үүнд: Татварын бус орлогын төрлөөр төсөвт байгууллагын өөрийн орлогоос 183.5 сая төгрөг төлөвлөсөн боловч, үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих эх үүсвэрт мөн тухайн төсөвт байгууллагуудаас оруулахаар 183.5 сая төгрөг төлөвлөгдсөн байна.

Өмнөх онуудад хийгдсэн санхүү, нийцэл, гүйцэтгэлийн аудитаар орон нутгийн орлогын төлөвлөлттэй холбоотой өгч байсан зөвлөмж, албан шаардлагуудын хэрэгжилтийг тайлант оны аудитаар давтан шалгахад:

Аймгийн Засаг даргын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар сумуудын Засаг дарга нарт “Малын тоо, толгойн албан татвараас орох орлогыг үндэслэлтэй төлөвлөж, сумын ИТХ-аар батлуулж, сумын төсвийн орлогод бүрэн төвлөрүүлж ажиллах” талаар зөвлөмж хүргүүлж байсан.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2023 оны аудитаар шалгахад Алтанцөгц сумаас бусад сумууд малын тоо толгойн албан татварыг сумын ИТХ-аар батлуулж зөвлөмжийг хэрэгжүүлсэн боловч тайлант оны аудитаар Алтай, Алтанцөгц, Дэлүүн, Өлгий сум болон Цагааннуур тосгон зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байна.

Хүснэгт №5 **Малын тоо, толгойн албан татварын төлөвлөлт**

сая төгрөгөөр

№	Сумын нэр	Малын тоо, толгойн албан татварын төлөвлөгөө
---	-----------	--

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2024 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

		2022 он	2023 он	2024 он
1	Алтай		9.5	
2	Алтанцөгц			
3	Баяннуур		49.3	40.0
4	Бугат		11.2	8.5
5	Булган		78.3	35.9
6	Буянт	90	82.1	35.0
7	Дэлүүн	90	92.6	-
8	Ногооннуур		18.5	10.6
9	Сагсай		14.1	28.0
10	Толбо	30.5	43.5	38.2
11	Улаанхус		56.8	21.7
12	Цэнгэл		248.3	115.5
13	Өлгий		3.8	-
	БҮГД	210.5	708.0	333.4

Эх сурвалж: Сумуудын малын тоо, толгойн албан татварын төлөвлөлт

Сумуудын малын тоо, толгойн албан татварын төлөвлөгөө өмнөх оноос 374.6 сая төгрөгөөр буурсан нь зарим сум малын тоо, толгойн албан татварын орлогыг төлөвлөж, батлаагүй байгаатай холбоотой байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтэд 2023 онд хийсэн аудитаар “Байгалийн нөөц ашигласны төлбөрийг бодитой тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөх” талаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгахад байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос хуульд заасан хувь хэмжээгээр тооцож байгаль орчин хамгаалах, нөхөн сэргээх зардалд 669.8 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж баталсан байна.

Хүснэгт №6 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчин хамгаалах, нөхөн сэргээх зардалд төлөвлөсөн байдал сая төгрөгөөр

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төрөл	Анх баталсан төсөв	БОХ, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хувь, хэмжээний доод хязгаар /нийт орлогын дүнгээс хувиар/	Байгаль орчин хамгаалах нөхөн сэргээх зардалд баталсан	Тодотгосон төсөв	Байгаль орчин хамгаалах нөхөн сэргээх зардалд батлалав зохих	Зөрүү
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	225.0	15%	33.8	246.4	37.0	3.2
Ус, рашаан ашигласны төлбөр	25.0	35%	8.8	26.4	9.2	0.5
Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр	52.5	85%	44.6	52.2	44.4	-0.3
Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж	1,165.5	50%	582.8	1,670.6	835.3	252.5
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	-	15%	0.0	0.0	0.0	0.0
Дүн	1,468.0		669.9	1,995.6	925.9	256.0

1.2 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ТӨЛӨВЛӨЛТ

1.2.1 Орон нутгийн төсвийн нийт зарлагын төлөвлөлт

Сангийн яамны хянаж ирүүлсэн тус аймгийн 2024 оны төсвийн нийт зарлага 55,113.1 сая төгрөг байна.

Аймгийн ИТХ-ын “Баян-Өлгий аймгийн 2024 оны төсөв батлах тухай” 2023 оны 221 дүгээр тогтоолоор баталсан төсвийн нийт зарлагын төлөвлөгөө 64,241.0 сая төгрөг байна.

Аймгийн ИТХ-ын “Аймгийн 2024 оны төсөвт тодотгол хийх тухай” 2024 оны 257 дугаар тогтоолоор төсвийн нийт зарлагыг 73,754.9 сая төгрөгөөр, 262 дугаар тогтоолоор 73,579.6 сая төгрөгөөр тус тус тодотгож баталсан байна.

Хүснэгт №7 Орон нутгийн зарлагын төлөвлөгөө

сая төгрөгөөр

Үзүүлэлт	Сангийн яамны хянасан суурь	Аймгийн ИТХ-ын 2023 оны 12.02-ны 221 дүгээр тогтоол	Аймгийн ИТХ-ын 2024 оны 257 дугаар тогтоол	Аймгийн ИТХ-ын 2024 оны 262 дугаар тогтоол	Сумуудын ИТХ-ын тогтоолоор баталсныг нэмсэн дүнгээр	Зөрүү	
А	1	2	3	4	5	/2-1/	/5-2/
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	55,113.1	64,241.0	73,754.9	73,579.6	80,779.0	9,127.9	16,424.4
УРСГАЛ ЗАРДАЛ	41,004.2	45,573.2	52,055.8	52,197.5	56,340.6	4,569.0	10,767.4
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	38,658.1	43,267.6	49,949.1	50,048.4	54,325.3	4,609.5	11,057.7
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	16,934.2	18,241.9	19,638.6	19,521.6	20,350.4	1,307.7	2,108.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,116.8	2,280.2	2,454.8	2,440.6	2,527.2	163.5	247.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,394.9	13,755.8	14,290.2	15,375.8	15,186.7	1,360.9	1,430.9
Хангамж, бараа материалын зардал	792.1	798.7	860.8	852.8	1,025.3	6.6	226.6
Нормативт зардал	228.9	249.6	311.5	311.5	318.9	20.7	69.3
Эд хогшил, урсгал засварын зардал	393.6	411.5	457.6	440.1	693.8	18.0	282.3
Томилолт, зочны зардал	254.9	284.4	371.4	336.4	337.1	29.6	52.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,028.1	2,444.4	2,967.2	2,898.7	2,961.4	416.3	516.9
Бараа үйлчилгээний бусад зардал	3,514.8	4,801.0	8,597.0	7,871.0	10,924.5	1,286.3	6,123.5
ТАТААС		113.6	113.6	113.6		113.6	(113.6)
ХҮҮ	113.6	-	-	-	-	(113.6)	-
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,232.4	2,192.0	1,993.1	2,035.5	2,015.3	(40.5)	(176.6)
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	14,108.9	18,667.8	21,699.1	21,382.1	24,324.8	4,558.9	5,657.0
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-	-	-	-	113.6	-	113.6
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	55,113.1	64,241.0	73,754.9	73,579.6	80,779.0	9,127.9	-
Орон нутгийн төсвөөс санхүүжих	55,070.7	63,977.5	71,621.8	71,526.5	73,980.3	8,906.8	-
Орон нутгийн төсвөөс санхүүжих	43,664.1	52,571.0	60,215.2	59,576.9	62,030.8	8,906.8	-
Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	11,406.6	11,406.6	11,406.6	11,949.5	11,949.5	-	-

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2024 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	42.4	263.5	2,133.2	2,053.2	6,798.7	221.1	-
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	42.4	263.5	263.5	183.5	1,724.1	221.1	-
Урьд оны үлдэгдлээс			1,869.7	1,869.7	5,074.6	-	-

Эх сурвалж: Аудитын судалгаа

Аймгийн 2024 оны төсвийн зарлагын төлөвлөлтийг анх баталсан дүнтэй харьцуулж өөрчлөлтийг зардлын бүлгээр авч үзэхэд:

Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, НДШ-ийн зардлыг 2,355.5 сая төгрөгөөр, байр ашиглахтай холбоотой тогтмол зардлыг 1,430.9 сая төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 226.6 сая төгрөгөөр, нормативт зардлыг 69.3 сая төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 282.3 сая төгрөгөөр, томилолтын зардлыг 52.7 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 516.9 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 6,123.5 сая төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 5,657.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, урсгал шилжүүлгийг 176.6 сая төгрөгөөр бууруулж баталсан байна.

Хүснэгт №8 Орон нутгийн төсвийн суурь орлого, зарлагын төлөвлөлт

сая төгрөгөөр

№	Үзүүлэлт	Баян-Өлгий аймаг 2024 он					Анх батлагдсан дүнгээс өссөн/буурсан
		Сангийн яамны хянасан дүн	Анх батлагдсан	Тодотгол-1	Тодотгол-2	Тодотгол /Сумуудын нэмж баталсан дүнгээр/	
А	Б	1	2	3	4	5	6
	ИТХ-ын шийдвэрийн огноо, дугаар						
	ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН СУУРЬ ОРЛОГО	18,352,579.7	27,163,651.8	36,677,530.1	39,549,528.7	58,698,486.9	31,534,835.1
	НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	18,352,579.7	27,163,651.8	36,677,530.1	39,549,528.7	58,698,486.9	31,534,835.1
	УРСГАЛ ОРЛОГО	18,352,579.7	27,163,651.8	34,807,880.0	37,679,878.7	39,825,782.3	12,662,130.5
	Татварын орлого	16,696,564.0	24,786,549.4	31,333,593.9	34,191,082.7	36,229,901.0	11,443,351.6
	Татварын бус орлого	1,656,015.7	2,377,102.5	3,474,286.1	3,488,796	3,595,881.3	1,218,778.8
	ХӨРӨНГИЙН ОРЛОГО					11,949,543.0	11,949,543.0
	ТУСЛАМЖИЙН ОРЛОГО						0.0
	ӨМНӨХ ХЭМНЭГДСЭН ЗАРДАЛ, ТЭНЦЛИЙН АШИГ						0.0
	ӨМНӨХ ОНЫ ДАНСНЫ ҮЛДЭГДЭЛ			1,869,650.1	1,869,650.0	5,199,055.8	5,199,055.8
	СУМДЫН ТУСГАЙ САНГУУД					1,724,105.8	1,724,105.8
	ГАДААДЫН ТӨСЛИЙН ЗЭЭЛЭЭС						0.0
	ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН СУУРЬ ЗАРЛАГА	43,706,542.9	52,834,452.4	62,348,330.1	61,630,084.1	80,779,042.3	27,944,589.9
	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	43,706,542.9	52,834,452.4	62,348,330.1	61,630,084.1	80,779,042.3	27,944,589.9
	УРСГАЛ ЗАРДАЛ	41,004,193.5	45,573,203.1	52,055,780.7	52,197,534.7	56,340,622.8	10,767,419.8
	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	38,658,170.0	43,267,633.5	49,949,099.9	50,048,426.9	54,325,286.4	11,057,653.0
	ХҮҮ						0.0
	ТАТААС	113,602.5	113,602.5	113,602.5	113,602.5		-113,602.5
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,232,421.0	2,191,967.2	1,993,078.4	2,035,505.3	2,015,336.4	-176,630.8
	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,702,349.4	7,261,249.4	10,292,549.4	9,432,549.4	24,324,817.0	17,063,567.7
	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН					113,602.5	113,602.5

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2024 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

ЦЭВЭР ЗЭЭЛ						
УРСГАЛ ТЭНЦЭЛ	-22,651,613.8	18,409,551.2	17,247,900.7	14,517,656.0	16,514,840.5	1,894,710.7
НИЙТ ТЭНЦЭЛ	-25,353,963.2	25,670,800.6	25,670,800.0	22,080,555.4	22,080,555.4	3,590,245.2

Эх сурвалж: Аудитын судалгаа

Аймгийн ИТХ-ын “Аймгийн 2024 оны төсөв батлах тухай” 2023 оны 221 дүгээр тогтоолоор аймгийн төсвийн суурь орлого, зарлагын нийт тэнцэл -25,670.8 сая төгрөг бөгөөд улсын төсвийн дэмжлэгээр санхүүжүүлэхээр төлөвлөж, 2024 онд төсвийн орлого, зарлагын төсөвт 2 удаа тодотгол хийгдсэн байна.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд Улсын Их Хурлын 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар орсон өөрчлөлтөөр тус аймагт олгох санхүүгийн дэмжлэгийг анх баталснаас 3,590.2 сая төгрөгөөр бууруулж баталсныг үндэслэж Аймгийн ИТХ-ын 2024 оны “Аймгийн 2024 оны төсөвт тодотгол хийх тухай” 262 дугаар тогтоолоор аймгийн төсвийн суурь орлого, зарлагын төсвийг тодотгож баталсан байна.

Орон нутгийн төсвийн орлого, зарлагын нийт тэнцэл -22,080.5 сая төгрөг ба улсын төсвийн дэмжлэгээр санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Аймгийн нэгдсэн төсвийн төлөвлөгөө 80,779.0 сая төгрөгийн 53.4 хувийг буюу 43,173.8 сая төгрөгийг сумуудын ТТЗ нарын төсөв, 46.5 хувийг буюу 37,605.2 сая төгрөгийг аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын төсөв эзэлж байна.

Ерөнхий дансны төлөвлөлт

Аймгийн ерөнхий данс нь Засгийн газрын санхүүгийн Э тайланд Ахмадын сан гэсэн нэрээр явж ирсэн байна.

Аймгийн ИТХ-ын 2023 оны 221 дүгээр тогтоолоор Засаг даргын ерөнхий дансаар ахмад настны хөгжил хамгаалалд зарцуулах төсвийг 107.6 сая төгрөгөөр, мал аж ахуйг хөгжүүлэх төсвийг 606.1 сая төгрөгөөр, мөрийн хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээний болон шүүхийн шийдвэр гарсан зардалд зарцуулах төсвийг 1,437.4 сая төгрөгөөр, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагийн албан хаагч нарын орон нутгийн нэмэгдэлд зарцуулах 10 хувьд 355.0 сая төгрөгийг буюу нийт 2,506.1 сая төгрөгийг баталсан байна.

Аймгийн ИТХ-ын “Аймгийн 2024 оны төсөвт тодотгол хийх тухай” 2024 оны 257 дугаар тогтоолоор Засаг даргын ерөнхий дансны мөрийн хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээний болон шүүхийн шийдвэр гарсан зардалд зарцуулах төсвийг 1,025.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж 2,463.2 сая төгрөгөөр, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагийн албан хаагч нарын орон нутгийн нэмэгдлийг 941.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж 1,296.4 сая төгрөгөөр, нийт төсвийг 4,473.3 сая төгрөгөөр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын “Аймгийн 2024 оны төсөвт тодотгол хийх тухай” 2024 оны 262 дугаар тогтоолоор Засаг даргын ерөнхий дансны мөрийн хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээний болон шүүхийн шийдвэр гарсан зардалд зарцуулах төсвийг өмнөх тодотгосон төсвийг 234.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 2,697.2 сая төгрөгөөр, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагийн албан хаагч

нарын орон нутгийн нэмэгдлийг өмнөх тодотгосон төсвийг 350.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 1,646.4 сая төгрөгөөр, нийт төсвийг 5,057.3 сая төгрөгөөр баталсан байна.

Энэ нь анх баталсан төсвөөс 2,551.2 сая төгрөгөөр илүү байна.

Аймгийн ОНХ-ийн сангийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжих төсөл, арга хэмжээний төлөвлөлт

Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас тус аймгийн Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 11,406.6 сая төгрөгөөр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын “Аймгийн 2024 оны төсөвт тодотгол хийх тухай” 2024 оны 262 дугаар тогтоолоор ОНХНС-гаас аймгийн ОНХС-д хуваарилсан орлогын шилжүүлгээс сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 7,057.8 сая төгрөгөөр, аймгийн ОНХС-д орлогын шилжүүлгийг 4,348.8 сая төгрөгөөр баталсан байна.

Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуульд УИХ-ын 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар оруулсан өөрчлөлтөөр тус аймгийн ОНХ-ийн санд ОНХ-ийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлгийг 542.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж 11,949.9 сая төгрөгөөр баталсныг үндэслэж аймгийн ИТХ-ын 2024 оны 262 дугаар тогтоолоор тодотгол хийсэн байна.

Сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 7,383.6 сая төгрөгөөр, аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 4,565.9 сая төгрөгөөр, аймгийн ОНХС-гийн урьд оны үлдэгдлээс санхүүжих дүнг 1,540.1 сая төгрөгөөр тодотгож баталсан байна.

Сумуудын ИТХ-ын тогтоолоор сумуудын орон нутгийн хөгжлийн сангийн урьд оны үлдэгдлээс санхүүжих дүнг 1,069.1 сая төгрөг, төсвийн шилжих үлдэгдэл 333.5 сая төгрөг, орлогын шилжүүлэг 7,383.6 сая төгрөг, нийт 8,786.2 сая төгрөгөөр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 262 дугаар тогтоолоор аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх шилжих хөрөнгө оруулалтаар хэрэгжих 35 төсөл, арга хэмжээнд 3,734.8 сая төгрөг, шинээр эхлэх хөрөнгө оруулалтын 28 төсөл, арга хэмжээнд 614.0 сая төгрөг, нийт 4,548.8 сая төгрөг баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2024 оны “Аймгийн 2024 оны төсвийн тодотгол батлах тухай” 257 дугаар тогтоолоор аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөөнд өөрчлөлт оруулаагүй байна.

Аймгийн ИТХ-ын 2024 оны “Аймгийн 2024 оны төсвийн тодотгол батлах тухай” 262 дугаар тогтоолоор аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх шилжих хөрөнгө оруулалтаар хэрэгжих 32 төсөл, арга хэмжээнд 3,444.3 сая төгрөг, шинээр эхлэх хөрөнгө оруулалтын 54 төсөл, арга хэмжээнд 1,121.6 сая төгрөг, урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр 22 төсөл арга хэмжээнд 1,540.1 сая төгрөг, нийт 6,106.0 сая төгрөг баталсан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт

Аймгийн ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 262 дугаар тогтоолоор аймгийн 2024 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх 48 төсөл, арга хэмжээнд 4,558.9 сая төгрөг, аймгийн Эрүүл мэнд, Боловсрол, соёлын салбарын засварын хөрөнгөөр шилжих хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 7 төсөл, арга хэмжээнд 288.8 сая төгрөг, шинээр хэрэгжүүлэх 42 төсөл, арга хэмжээнд 2,413.5 сая төгрөгийн, нийт 7,261.2 сая төгрөг төлөвлөж баталсан байна.

Аймгийн 2024 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх 48 төсөл, арга хэмжээнд батлагдсан 4,558.9 сая төгрөгийн 43.8 хувийг буюу 2,000.0 сая төгрөгийг аймгийн сургууль, цэцэрлэгүүдэд хатуу, зөөлөн эдлэл худалдан авахад, 21.5 хувийг буюу 981.0 сая төгрөгийг аймгийн төрийн албан хаагчдыг компьютержуулах арга хэмжээнд зориулан баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2024 оны “ Аймгийн 2024 оны төсвийн тодотгол батлах тухай” 257 дугаар тогтоолоор аймгийн Орон нутгийн төсвөөр 2024 онд хэрэгжих 143 төсөл арга хэмжээнд 7,428.5 сая төгрөг, Боловсрол, Эрүүл мэнд, Соёлын салбарын их засварын 49 төсөл, арга хэмжээнд 2,702.0 сая төгрөг, өмнөх оны үлдэгдлээс санхүүжих 3 төсөл арга хэмжээнд 161.7 сая төгрөгийг, нийт 10,292.5 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж анх баталснаас 3,031.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж тодотгож баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2024 оны “ Аймгийн 2024 оны төсвийн тодотгол батлах тухай” 262 дугаар тогтоолоор аймгийн Орон нутгийн төсвөөр 2024 онд хэрэгжих 134 төсөл арга хэмжээнд 6,568.5 сая төгрөг, Боловсрол, Эрүүл мэнд, Соёлын салбарын их засварын 49 төсөл, арга хэмжээнд 2,702.0 сая төгрөг, өмнөх оны үлдэгдлээс санхүүжих 3 төсөл арга хэмжээнд 161.7 сая төгрөгийг, нийт 9,432.5 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж анх баталснаас 2,171.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 257 дугаар тогтоолоор тодотгож баталсан дүнгээс 860.0 сая төгрөгөөр бууруулж баталсан байна.

Замын сангийн төлөвлөлт

Аймгийн ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 262 дугаар тогтоолоор Замын сангийн төсвийг 1,863.9 сая төгрөгөөр төлөвлөж баталсан ба 2024 оны 257 дугаар тогтоолоор орон нутгийн 500.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 2,363.9 сая төгрөгөөр, урьд оны үлдэгдлээс санхүүжих дүнг 236.2 сая төгрөгөөр буюу анх баталснаас 736.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж 2,600.1 сая төгрөгөөр тодотгож баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2024 оны 262 дугаар тогтоолоор Замын сангийн орон нутгийн төсвөөс санхүүжих дүнг 1,000 сая төгрөгөөр бууруулж 33 төсөл, арга хэмжээнд 1,363.9 сая төгрөгөөр, 236.2 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр, нийт 1,600.1 сая төгрөгөөр тодотгож анх баталснаас 263.8 сая төгрөгөөр, өмнөх тодотголоор баталснаас 1,000.0 сая төгрөгөөр бууруулж баталсан байна.

БҮЛЭГ 2. ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Орон нутгийн орлого, зардлыг үндэслэлгүй нэмэгдүүлж төлөвлөснөөс тайлант оны орон нутгийн нэгдсэн төсвийн төлөвлөгөө биелэгдээгүй байна

2.1. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ

2.1.1 Орон нутгийн төсвийн нийт орлогын гүйцэтгэл

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө 93.4 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна

Баян-Өлгий аймгийн 2024 оны орон нутгийн төсвийн орлогын нийт төлөвлөгөө 80,779.0 сая төгрөг ба гүйцэтгэлээр 75,451.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж орлогын төлөвлөгөө 5,327.2 сая төгрөгөөр буюу 6.6 хувиар тасарсан байна.

Хүснэгт №9 Орон нутгийн төсвийн нийт орлогын гүйцэтгэл

сая төгрөгөөр

Үзүүлэлт	2023 оны нийт орлого, эх үүсвэр	2024 оны төсвийн орлогын			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Татварын орлого	18548.8	36,229.9	33,641.2	-2,588.7	92.8
Татварын бус орлого	2362.4	3,595.8	2,821.9	-773.9	77.8
Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	12789.5	22,080.6	22,080.6	0.00	100
Орон нутгийн хөгжлийн сангийн шилжүүлэг	9911.9	11,949.5	11,467.1	-482.5	95.9
Үндсэн үйл ажиллагааны орлогоос	1152.9	1,724.1	1,077.8	-646.3	62.5
Туслах үйл ажиллагааны орлогоос	24.9		198.4	198.4	100
Урьд оны үлдэгдлээс санхүүжих		5,199.1	4,118.4	-1,080.7	79.2
Төсвийн шилжих үлдэгдэл	513.9		46.4		100
Нийт орлогын дүн	45304.3	80,779.0	75,451.8	-5,327.2	93.4

Эх сурвалж: Орон нутгийн орлогын судалгаа

Орон нутгийн төсвийн суурь орлогын төлөвлөгөө 39,825.7 сая төгрөг ба гүйцэтгэлээр 36,463.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж төлөвлөгөө 3,362.6 сая төгрөгөөр буюу 8.4 хувиар тасарсан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогоос 1.724.1 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээс 1,540.6 сая төгрөг нь сумуудын Хоршоог хөгжүүлэх сангийн үндсэн үйл ажиллагааны орлогоос орох орлого ба гүйцэтгэлээр 1,077.8 сая төгрөг оруулж, төлөвлөгөө 462.8 сая төгрөгөөр тасарсан байна.

Туслах үйл ажиллагааны орлогоос 198.4 сая төгрөгийн орлого оруулсан байна.

Улсын төсвөөс авах 22,080.6 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг бүрэн авч, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлгээр 11,467.1 сая

төгрөгийн санхүүжилт авч төлөвлөснөөс 482.5 сая төгрөгөөр дутуу санхүүжүлжээ.

2.1.2 Орон нутгийн суурь орлогын гүйцэтгэл

Орон нутгийн төсвийн суурь орлогын төлөвлөгөө 3,362.6 сая төгрөгөөр тасарсан байна.

Аймгийн 2024 оны орон нутгийн төсвийн суурь орлогын төлөвлөгөө 39,825.8 сая төгрөг ба гүйцэтгэлээр 36,463.2 сая төгрөгийн орлого орж, орлогын төлөвлөгөө 8.4 хувиар буюу 3,362.6 сая төгрөгөөр тасарсан байна. /ХХОАТ-ын буцаалтыг хассан дүнгээр/

Татварын орлогын төлөвлөгөө 2,588.7 сая төгрөгөөр, татварын бус орлогын төлөвлөгөө 774.0 сая төгрөгөөр тасарсан байна.

Хүснэгт №10 Орон нутгийн суурь орлогын гүйцэтгэл

сая төгрөгөөр

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
СУУРЬ ОРЛОГО	39,825.8	36,463.2	(3,362.6)
УРСГАЛ ОРЛОГО	39,825.8	36,463.2	(3,362.6)
ТАТВАРЫН ОРЛОГО	36,229.9	33,641.2	(2,588.7)
Орлогын албан татвар	29,854.0	28,365.0	(1,489.0)
ХАОАТатвар	29,854.0	28,365.0	(1,489.0)
Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татвар	24,248.3	21,686.1	(2,562.2)
Үйл ажиллагааны орлого	4,498.4	5,532.4	1,034.1
Хөрөнгийн орлого	1,889.5	1,921.0	31.5
Хөрөнгө борлуулсны орлогын албан татвар	901.7	910.4	8.7
ХХОАТатварын буцаан олголт	(1,683.9)	(1,685.0)	(1.1)
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	1,450.0	722.3	(727.7)
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	1,450.0	722.3	(727.7)
Хөрөнгийн татвар	1,623.4	1,690.1	66.7
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	480.0	524.2	44.2
Бууны албан татвар	60.0	55.4	(4.6)
Малд ногдуулах албан татвар	333.4	268.9	(64.5)
АТӨЯХАТатвар	750.0	841.6	91.6
Бусад татвар	1,072.7	795.3	(277.4)
Улсын тэмдэгтийн хураамж	679.3	727.1	47.8
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	246.4	39.6	(206.8)
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	117.0	28.6	(88.4)
Бусад татвар	30.0		(30.0)
Газрын төлбөр	480.6	469.4	(11.2)
Газрын төлбөр	480.6	469.4	(11.2)
Байгалийн нөөц ашигласны төлбөр	1,749.2	1,599.1	(150.0)

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2024 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Ойн нөөц ашигласны төлбөр	52.2	35.5	(16.7)
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	1,670.6	1,544.9	(125.7)
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	26.4	18.7	(7.7)
II.Татварын бус орлого	3,595.9	2,821.9	(774.0)
Хүүгийн орлого		0.5	0.5
Торгуулийн орлого	2,230.7	1,175.0	(1,055.7)
Төсөвт газрын өөрийн орлого	183.5	162.4	(21.1)
Бусад нэр заагдаагүй орлого	1,181.7	1,484.0	302.3

Эх сурвалж: Аудитын судалгаа

Орлогын гүйцэтгэлийг нэр төрлөөр авч үзвэл: Татварын орлогоос цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татвар, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, бууны албан татвар, малд ногдуулах татвар, түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, хог хаягдлын үйлчилгээний хураамж, бусад татвар, газрын төлбөр, ойн нөөц ашигласны төлбөр, ан амьтны нөөц ашигласны төлбөр, ус рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого нийт дүнгээрээ 3,845.5 сая төгрөгөөр тасарсан байна.

Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татварын төлөвлөгөө 2,562.2 сая төгрөгөөр тасарсан нь тасарсан татварын орлогын 67 хувийг эзэлж байгаа нь төлөвлөлт үндэслэлгүй байгаатай холбоотой байна.

Үйл ажиллагааны орлого, хөрөнгийн орлого, хөрөнгө борлуулсны орлогын албан татвар, үл хөдлөх хөрөнгийн албан татвар, авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татвар, улсын тэмдэгтийн хураамжууд нийт дүнгээр 1,257.9 сая төгрөгөөр давж биелэгдсэн байна. Үйл ажиллагааны орлого 1,034.1 сая төгрөгөөр давж биелсэн нь “Эрдэнэс таван толгой” ХХК-иас орсон ноогдол ашгийн орлоготой холбоотой байна.

Татварын бус орлогын гүйцэтгэлийг орлогын нэр төрлөөр авч үзвэл нийт дүнгээрээ 774.0 сая төгрөгөөр тасарсан байна. Хүү, торгуулийн орлогын төлөвлөгөө 1,055.7 сая төгрөгөөр, төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөө 21.1 сая төгрөгөөр тасарч, бусад нэр заагдаагүй орлогын төлөвлөгөө 302.3 сая төгрөгөөр давж биелэгдсэн байна.

Бусад нэр заагдаагүй орлогын дийлэнх хувийг газрын анхны үнэ, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас орсон орлого, аудит, хяналт шалгалтын төлбөрийн актын дансны орлого бүрдүүлж байна.

Сумуудын орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө 2,612.5 сая төгрөгөөр, аймгийн төсвийн орлогын төлөвлөгөө 750.0 сая төгрөгөөр тасарсан байна.

*Хүснэгт №11 Орон нутгийн суурь орлогын гүйцэтгэл / аймаг, сумаар/
сая төгрөгөөр*

№	Сумын нэр	2024 он			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
		1	2	/2-1/	2/1.

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2024 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

1	Алтай	1,065.80	1,073.50	7.70	100.7
2	Алтанцөгц	545.4	552.2	6.80	101.2
3	Баяннуур	890.4	799.5	-90.90	89.8
4	Бугат	755.9	694.5	-61.40	91.9
5	Булган	1,310.90	1,235.10	-75.80	94.2
6	Буянт	673.3	616.3	-57.00	91.5
7	Дэлүүн	2,049.90	1,986.20	-63.70	96.9
8	Ногооннуур	1,312.80	1,323.90	11.10	100.8
9	Сагсай	1,089.70	1,398.70	309.00	128.4
10	Толбо	813.8	756.1	-57.70	92.9
11	Улаанхус	2,071.40	1,887.20	-184.20	91.1
12	Цэнгэл	2,239.90	1,875.20	-364.70	83.7
13	Цагааннуур	1,135.70	916.2	-219.50	80.7
14	Өлгий	18,867.00	17,094.80	-1,772.20	90.6
15	Татварын хэлтэс	5,003.80	4,253.80	-750.00	85.0
	БҮГД	39,825.70	36,463.20	-3,362.50	91.6
	Аймгийн дүн	5,003.80	4,253.80	-750.00	85.0
	Сумуудын дүн	34,821.90	32,209.40	-2,612.50	92.5

Эх сурвалж: Орон нутгийн орлогын судалгаа

Алтай, Алтанцөгц, Ногооннуур, Сагсай сум орлогын төлөвлөгөөг 0.7-28.4 хувиар давуулан биелүүлж, бусад 10 сум орлогын төлөвлөгөөг 3.1-19.3 хувиар, Татварын хэлтэс аймгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 15 хувиар тус тус тасалсан байна.

Татварын ерөнхий газраас сар бүр улс, орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл, үр дүнг тооцож үр дүнгийн шагнал олгох хувийг баталж ирүүлдэг байна.

Хүснэгт №12

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл үр дүнгийн шагнал олгосон хувь

сая төгрөгөөр

Сар	Аймгийн төсөв				Сумын төсөв				
	Төл	Гүй	Хувь	Үр дүнгийн шагнал олгох хувь	Төл	Гүй	Хувь	Үр дүнгийн шагнал олгох хувь	Төл биелсэн сум
1-р сар	119.8	142.4	118.9	10	1300.7	1076.2	82.7		1 сум
2-р сар	46.1	164.8	357.6	10	1373.2	2271.3	165.4	10	13 сум
3-р сар	60.8	307.3	505.9	10	1443.3	1671.3	115.8	10	6 сум
4-р сар	216.6	290.5	134.1	10	2846.8	4847.7	170.3	10	13 сум
5-р сар	133.7	271.7	203.3	10	1848.1	2497.3	135.1	10	14 сум
6-р сар	107.2	205.1	191.3	10	2739.3	2923.7	109.7	10	10 сум
7-р сар	69	147.4	213.7	10	1117.2	1647.9	147.5	10	10 сум
8-р сар	63.3	72.3	114.3	10	1560.3	2694.4	172.7	10	2 сум
9-р сар	97.1	124.7	128.5	10	2029.7	3008.1	148.2	10	11 сум

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2024 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

10-р сар	126.2	164.5	130.4	10	2744.9	2484.8	90.5	10	6 сум
11-р сар	94.9	102.3	107.8	10	2790.1	2370.4	85		7 сум
12-р сар	1,078.9	1220.1	113.1	10	12267.5	8491.7	69.2		3 сум
	2,213.6	3,213.1	145.15		34,061.1	35,984.8	105.6	90	

Эх сурвалж: ТУНС-ийн сар бүрийн мэдээ

Татварын удирдлагын нэгдсэн системд нэгтгэсэн орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл нь аймгийн ТЕЗ-ийн 2024 оны орон нутгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлээс зөрүүтэй байна. Тухайлбал: төлөвлөгөө нь 3,551.0 сая төгрөгөөр бага, гүйцэтгэл нь 2,734.7 сая төгрөгөөр илүү байна.

Аймгийн 2024 оны орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлт 91.6 хувийн гүйцэтгэлтэй 3,362.5 сая төгрөгөөр тасарсан байхад Татварын нэгдсэн удирдлагын систем дэх мэдээллээр гүйцэтгэл давж биелэгдсэн мэдээлэлтэй байгаа нь үндэслэлгүй байна.

Аймаг, сумын татварын байцаагчид 2024 онд сар бүр татварын орлогын төлөвлөгөөг биелүүлсний үр дүнгийн шагнал авч ирсэн бөгөөд татварын орлогын төлөвлөгөө биелэгдээгүй сумын татварын улсын байцаагчдад үр дүнгийн шагнал олгогдоогүй байна.

2.2 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ

Орон нутгийн төсвийн зарлага төлөвлөснөөс 10,020.5 сая төгрөгөөр бага гүйцэтгэлтэй гарсан байна.

2.2.1 Төсвийн зарлагын гүйцэтгэл

Төсвийн байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан 855.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна

Орон нутгийн нэгдсэн төсвийн 2024 оны зарлагын ний төлөвлөгөө 80,779.0 сая төгрөг ба 70,758.5 сая төгрөгийн гүйцэтгэлтэй гарсан байна. Төсвийн зарлагын гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулахад 29,572.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт №13 Төсвийн нийт зарлагын гүйцэтгэл

сая төгрөгөөр

Үзүүлэлт	2023 оны гүйцэтгэл	2024 он			Зөрүү өмнөх оны гүйцэтгэл
		Төлөв лөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	
А	1	2	3	/3-2/	/3-1/
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	41,185.9	80,779.0	70,758.5	-10,020.5	29,572.6
УРСГАЛ ЗАРДАЛ	29,992.5	56,340.6	50,974.9	-5,365.7	20,982.4
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	29,460.6	54,325.3	49,102.7	-5,222.6	19,642.1
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	11,112.9	20,350.4	19,579.5	-770.9	8,466.6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,435.5	2,527.2	2,491.5	-35.7	1,056.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,168.4	15,186.7	13,686.0	-1,500.7	3,517.6
Хангамж, бараа материалын зардал	812.4	1,025.3	974.8	-50.6	162.4
Нормативт зардал	228.4	318.9	314.2	-4.7	85.8
Эд хогшил, урсгал засварын зардал	451.2	693.8	594.9	-98.9	143.7

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2024 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Томилолт, зочны зардал	259.7	337.1	291.8	-45.3	32.1
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,442.3	2,961.4	2,674.5	-286.9	1,232.2
Бараа үйлчилгээний бусад зардал	3,549.8	10,924.5	8,495.5	-2,429.0	4,945.7
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	531.9	2,015.3	1,872.2	-143.1	1,340.3
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,893.4	24,324.8	19,783.6	-4,541.2	8,890.2
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	300.0	113.6	0.0	-113.6	-300.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	42,955.6	80,779.0	71,333.4	-4,371.0	28,377.8
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	41,802.6	73,980.3	69,894.7	-4,085.6	28,092.1
Орон нутгийн төсвөөс санхүүжих	31,890.6	62,030.8	58,427.7	-3,603.1	26,537.1
Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	9,912.0	11,949.5	11,467.1	-482.4	1,555.1
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,153.0	6,798.7	1,438.6	-285.5	285.6
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,128.0	1,724.1	1,240.2	-483.9	112.2
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	25.0		198.4	198.4	173.4
Урьд оны үлдэгдлээс санхүүжих		5,074.6		-5,074.6	0.0
Мөнгөний эхний үлдэгдэл	2,348.7		4,118.4	4,118.4	1,769.7
Мөнгөний эцсийн үлдэгдэл	4,118.4		4,693.3	4,693.3	574.9

Эх сурвалж: Аймгийн ТЕЗ-ийн 202 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нийт зарлагын 71.9 хувийг буюу 50,974.9 сая төгрөгийг урсгал зардал, 27.9 хувийг буюу 19.8 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 2.6 хувийг буюу 1,872.2 сая төгрөгийг урсгал шилжүүлэг эзэлж байна.

Батлагдсан төсөвтэй харьцуулахад бараа үйлчилгээний зардал 5,222.6 сая төгрөгөөр, урсгал шилжүүлэг 143.1 сая төгрөгөөр, хөрөнгийн зардал 4,541.2 сая төгрөгөөр төлөвлөснөөс бага гүйцэтгэлтэй гарсан байна.

Цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардал 770.9 сая төгрөгөөр бага гүйцэтгэлтэй гарсан нь орон нутгийн байгууллагууд орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэлтэй холбоотой төсвийг дутуу авч бага гүйцэтгэлтэй гарсан байна.

Бараа үйлчилгээний зардлаас байр ашиглахтай холбоотой тогтмол зардал төлөвлөснөөс 1,500.7 сая төгрөгөөр бага гүйцэтгэлтэй гарахад аймгийн Нэгдсэн эмнэлэг 434.8 сая төгрөгийн, Ерөнхий боловсролын сургуулиуд 448.1 сая төгрөгийн, Сургуулийн өмнөх боловсролын байгууллагууд 160.9 сая төгрөгийн, Эрүүл мэндийн төвүүд 95.6 сая төгрөгийн, Соёлын байгууллагууд 243.8 сая төгрөгийн, МСҮТөв 4.6 сая төгрөгийн, Өрхийн Эрүүл мэндийн төвүүд 2.0 сая төгрөгийн, Соёл, спорт аялал жуулчлалын газар 21.9 сая төгрөгийн, Хөгжимт драмын театр 3.5 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу авсан нь нөлөөлсөн байна.

Бараа үйлчилгээний бусад зардал төлөвлөснөөс 2,429.0 сая төгрөгөөр бага гүйцэтгэлтэй гарсан нь:

Сумуудын Хоршоог хөгжүүлэх сангуудын зээл олголттой холбоотой төлөвлөснөөс 1,111.9 сая төгрөгийн гүйцэтгэлтэй гарсан нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт:

Аймгийн Засаг даргын харьяа байгууллагуудын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар төсвийн үр ашиггүй зарцуулалттай холбоотой 855.0 сая төгрөгийн зөрчил илэрч 92.7 сая төгрөгийн зөрчилд 30 төлбөрийн акт тогтоож, 418.9 сая төгрөгийн зөрчилд 18 албан шаардлага, 343.4 сая төгрөгийн зөрчилд 14 заалт бүхий зөвлөмж хүргүүлсэн.

Төсвийн гүйцэтгэлийг байгууллагаар авч үзвэл: Хот тохижуулах албанаас бусад бүх байгууллага төлөвлөснөөс бага гүйцэтгэлтэй гарсан байна.

Хүснэгт №14 Төсвийн нийт зарлагын гүйцэтгэлийг байгууллагаар харуулбал

Байгууллага	2024 оны		Зөрүү
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
Сумуудын ЗДТГ	16,805.5	15,729.7	-1,075.8
Сумуудын ИТХ	3,337.6	2,891.0	-446.6
Аймгийн ОНХС	6,106.0	5,315.5	-790.5
Сумуудын ОНХС	8,786.2	6,323.7	-2,462.5
Орон нутгийн хөрөнгө оруулалт	9,432.5	8,144.4	-1,288.2
Сум хөгжүүлэх сан	1,540.6	428.6	-1,112.0
ЕБ-ын байгууллагуудын тогтмол зардал	6,667.2	6,219.1	-448.1
СӨБ-ын байгууллагуудын тогтмол зардал	2,875.3	2,714.4	-160.9
ЭМТ-үүдийн тогтмол зардал	698.9	603.4	-95.6
Соёлын төвүүдийн тогтмол зардал	881.7	637.9	-243.8
Хот тохижуулах алба	1,580.8	1,580.8	0.0
Аймгийн шууд	22,066.6	20,170.0	-1,896.6
ДҮН	80,779.0	70,758.5	-10,020.5

Эх сурвалж: Аудитын судалгаа

Аймгийн нэгдсэн төсвийн гүйцэтгэл 87.6 хувийн гүйцэтгэлтэй буюу 10, 020.5 сая төгрөгөөр тасарсан нь төсвийн орлого, зарлагын төлөвлөлт үндэслэлгүй хийгдсэнтэй холбоотой байна. Үүнд дараах шалтгаанууд голлох нөлөөг үзүүлсэн байна.

- Орон нутгийн төсвийн суурь орлогын төлөвлөгөөг үндэслэлгүй төлөвлөсөнтэй холбоотой орон нутгийн төсвийн орлого 3,362.6 сая төгрөгөөр тасарч орон нутгийн төсөвт байгууллагуудад санхүүжилт дутуу олгогдож гүйцэтгэл төлөвлөснөөс бага гарсан, орон нутгийн төсвөөс санхүүжих төсвийг 1,309.5 сая төгрөгөөр дутуу авсантай холбоотой орон нутгийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө 1,288.1 сая төгрөгөөр тасарсан байна.

- Сумуудын Хоршоог хөгжүүлэх сангуудын үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 462.8 сая төгрөгөөр тасарснаас гадна зээлийг төлөвлөсөн хэмжээгээр олгоогүйтэй холбоотой төлөвлөгөө 1,111.9 сая төгрөгөөр төлөвлөснөөс бага гүйцэтгэлтэй гарсан.
- Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас авах орлогын шилжүүлгийг 482.5 сая төгрөгөөр дутуу авсан, орон нутгийн хөгжлийн сангуудын төлөвлөсөн төсөл, арга хэмжээний гүйцэтгэл бүрэн хэрэгжээгүйгээс сумуудын орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө 2,462.5 сая төгрөгөөр, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө 790.5 сая төгрөгөөр тус тус төлөвлөснөөс бага гүйцэтгэлтэй байна.
- Орон нутгийн орлогын төлөвлөгөө тасарснаас эрүүл мэнд, боловсрол, соёлын байгууллагуудад олгох байр ашиглахтай холбоотой тогтмол зардлын санхүүжилт дутуу олгогдож, төлөвлөснөөс бага гүйцэтгэлтэй гарсан байна.

Аймгийн шууд төсвийн байгууллагуудын зардлын гүйцэтгэлийг байгууллага бүрээр дэлгэрэнгүй харуулбал:

Хүснэгт №15 Аймгийн төсвийн шууд байгууллагуудын төсвийн гүйцэтгэлийг байгууллагаар харуулбал

№	Аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагууд	Төлөвлөгөө	сая төгрөгөөр	
			Гүйцэтгэл	Зөрүү
1	Аймгийн ИТХурал	1,325.7	1093.9	(232)
2	Аймгийн ЗДТГазар	7,093.7	6369.1	(725)
3	Орон нутгийн хөрөнгө оруулалт	9,432.5	8144.4	(1,288)
4	Орон нутгийн хөгжлийн сан	6,106.0	5315.5	(791)
5	Замын сан	1,600.1	1425.7	(174)
6	Орон нутгийн халамжийн сан	196.0	151.7	(44)
7	Ахмадын сан	4,597.3	4566.3	(31)
8	МҮОНРТ	639.0	609.2	(30)
9	ОНӨ -ийн газар	468.8	417.3	(51)
10	Байгаль орчин аялал жуулчлалын газар	1,517.8	1513.5	(4)
11	Соёл, спорт, аялал жуулчлалын газар	411.2	389.2	(22)
12	Асрамжийн газар	393.5	381.9	(12)
13	Ойн анги	197.6	196.6	(1)
14	СХяналт, аудитын алба	391.7	363.7	(28)
15	Хөгжимт драмын театр	628.2	624.7	(3)
16	Нэгдсэн эмнэлэг	1,559.5	1124.7	(435)
17	ОНС музей	107.0	106.2	(1)
18	Номын сан	59.0	59.0	(0)
19	МСҮТ-ОН	337.7	333.0	(5)
20	насан туршийн боловсрол	7.7	7.5	(0)
21	Худалдан авах ажиллагааны алба	488.0	391.7	(96)
22	Өрхийн ЭМТ-үүдийн тогтмол зардал	47.0	45.0	(2)
	Дүн	37,605.2	33,629.9	(3,975)

Эх сурвалж: Аудитын судалгаа

Аймгийн Засаг даргын ерөнхий дансны зарцуулалт

Аймгийн ерөнхий дансаар Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын албан хаагч нарын орон нутгийн нэмэгдэлд 1,773.2 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Аймгийн ерөнхий дансны төлөвлөгөө 4,597.3 сая төгрөг, гүйцэтгэл 4,566.3 сая төгрөг байна.

Хүснэгт №16

Аймгийн ерөнхий дансны зарцуулалт

сая төгрөгөөр

Зарцуулалт	Мөнгөн дүн
Ахмадын хороонд	107.6
Мал эмнэлгийн газарт	606.1
Шүүхийн шийдвэрээр олгосон	339.7
Мөнгөн шагнал	58.0
Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ	155.7
ХБХүүхэдтэй эцэг эхчүүдийн холбоонд	30.0
ТҮНТөвийн тогтмол зардал	162.5
Сансар эмнэлгийн өр	439.4
Багш нарын баярын үйл ажиллагаанд	25.0
ЭЕШ-ын урамшуулалд	40.2
Ахмадын баярын үйл ажиллагаанд	150.0
МЗЭ-ийн салбар зөвлөл, бусад арга хэмжээ	129.9
Орон нутгийн нэмэгдэл 10-30 хувь	1,773.2
Загас агнуурын бүс тогтоох ажлын хөлс	23.8
Захирамжаар тамирчдад олгосон шагнал	39.6
Өмнөх оноос үлдсэн өвс тэжээл бэлтгэх бусад	408.5
Ерөнхийлөгчийн төрийн тахилга	77.3
Дүн	4,566.3

Эх сурвалж: Аудитын судалгаа

Аймгийн ерөнхий дансаар Засаг даргын захирамжаар зарцуулсан зардлууд:

- Ахмад настны хөгжил хамгаалал зардлаар Ахмадын хорооны үйл ажиллагааны санхүүжилтэд 107.6 сая төгрөгийн, мал аж ахуйг хөгжүүлэх арга хэмжээний зардалд 606.1 сая төгрөгийн санхүүжилт олгосон.
- Шүүхийн шийдвэр гарсан төсөвт байгууллагуудын халаалтын өрийн 230.0 сая төгрөг, шүүхийн 4 шийдвэрийн дагуу 109.7 сая төгрөг, нийт 339.7 сая төгрөгийг зарцуулсан.
- Үндэсний их баяр наадмаар “Улсын мэргэн” цол хүртсэн тамирчдад 58.0 сая төгрөгийн мөнгөн шагнал олгосон.
- Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээний зардал болох хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдэд 155.7 сая төгрөг, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн холбоонд 30.0 сая төгрөг, Төрийн үйлчилгээний нэгдсэн төсвийн тогтмол зардалд 162.5 сая төгрөг, Сансар эмнэлгийн өр төлбөрийг барагдуулахад 439.4 сая төгрөг олгосон байна.

- Монголын зохиолчдын эвлэлийн салбар зөвлөлийн үйл ажиллагаанд болон бусад хөтөлбөр, арга хэмжээний зардлуудад 129.9 сая төгрөг, ахмадын баярын үйл ажиллагаанд 150.0 сая төгрөг, элсэлтийн ерөнхий шалгалтын урамшуулалд 40.2 сая төгрөг, багш нарын баярын үйл ажиллагаанд 25.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.
- Орон нутаг дахь Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагийн төрийн албан хаагч нарын орон нутгийн нэмэгдэлд олгохоор баталсан 30 хувийн нэмэгдэлд нийтдээ 1,773.2 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.
- Өмнөх оноос үлдсэн өвс, тэжээл бэлтгэх арга хэмжээний зардалд 408.5 сая төгрөг, загас агнуурын бүс тогтоох ажлын хөлсөнд 23.8 сая төгрөг, тамирчдад 39.6 сая төгрөгийн шагнал, ерөнхийлөгчийн төрийн тахилгын зардалд 77.3 сая төгрөгийн зардал гаргасан байна.

Аймгийн Засаг даргын ерөнхий дансны гүйцэтгэл аймгийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн 6.5 хувийг эзэлж байна. Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын төрийн албан хаагч нарт орон нутгийн нэмэгдэлд олгосон 30 хувийн нэмэгдэл нь ерөнхий дансны зардлын 38.8 хувийг эзэлж байгаа нь үр ашиггүй зарцуулалт болсон ба орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлттэй уялдуулж төлөвлөөгүйтэй холбоотой байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэл

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлгийн төлөвлөгөө 11,949.5 сая төгрөг ба гүйцэтгэлээр 11,467.1 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авсан. Үүнээс 4,384.2 сая төгрөгийг аймгийн Орон нутгийн хөгжлийн санд, 7,082.9 сая төгрөгийг сумуудын Орон нутгийн хөгжлийн санд хуваарилсан байна.

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө 6,106.0 сая төгрөг, гүйцэтгэл 5,315.5 сая төгрөг оны эцэст зарцуулагдаагүй үлдэгдэл 943.1 сая төгрөг байна. Сумуудын Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө 8,786.2 сая төгрөг, гүйцэтгэл 6,323.7 сая төгрөг ба дараа онд шилжих үлдэгдэл 2,354.7 сая төгрөг байна.

Аймаг, сумын Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнүүдээс зарим төрлийн ажил хэрэгжсэн боловч гүйцэтгэлийн баримт бичгийг тайлант онд багтаан ирүүлээгүй зарим арга хэмжээнүүдийн санхүүжилт олгогдоогүйтэй холбоотой 2024 оны жилийн эцсийн тайлангаар нийт 1,894.8 сая төгрөгийн өглөгийг тайлагнасан байна. Үүнээс аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн өглөг 721.1 сая төгрөг, Дэлүүн сумын Орон нутгийн хөгжлийн сангийн өглөг 876.9 сая төгрөг байгаа нь ихэнх хувийг эзлэж байна.

Тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар сумуудын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалттай холбоотой хууль тогтоомж зөрчсөн нийт 1,340.7 сая төгрөгийн зөрчил илэрч 4 зөвлөмж, 7 албан шаардлага өгсөн байна. Үүнд:

Аудитын илрүүлэлт:

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс

Ногооннуур сумын Орон нутгийн хөгжлийн санд 36.5 сая төгрөгийн эзэнгүй өр төлбөрийг бүртгэсэн, 54.0 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг босго үнэд багтаах зорилгоор төсөвт өртгийг хувааж, шууд гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн, 80.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, эд хогшлыг худалдан авахдаа цахим худалдан авалтын журмыг хэрэгжүүлээгүй, гэрээ шууд байгуулах аргаар гүйцэтгүүлсэн.

Буянт сумын Орон нутгийн хөгжлийн сангаас Засгийн газрын 2010 оны 271 тоот тогтоолоор тогтоосон баяр наадмын зардлын дээд хэмжээг 3.0 сая төгрөгөөр хэтрүүлж зарцуулсан, 10.5 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг шууд гэрээгээр худалдан авч цахим худалдан авалтын журмыг зөрчсөн.

Дэлүүн сумын Орон нутгийн хөгжлийн сан Сумын ИТХ-ын 2024 оны 114 дугаар тогтоолоор баталсан төлөвлөгөөний хэрэгжилтийг хууль, журмын дагуу оновчтой зохион байгуулж хэрэгжүүлээгүйгээс оны эцэст 43 төсөл, арга хэмжээтэй холбоотой өглөгтэй гарсан, хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг босго үнэд багтаах зорилгоор ажлын төсөвт өртгийг 2 хувааж ИТХ-ын тогтоолоор батлуулан, гэрээ шууд байгуулах замаар гүйцэтгүүлсэн зэрэг 571.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн.

Цагааннуур тосгоны Орон нутгийн хөгжлийн сангаас 11.0 сая төгрөгийн тавилга эд хогшлыг шууд гэрээгээр худалдан авч цахим худалдан авалтын журмыг зөрчсөн.

Өлгий сумын Орон нутгийн хөгжлийн сангаас 416.0 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг зөрчсөн, 54.0 сая төгрөгийн бараа, ажил үйлчилгээг төрийн цахим худалдан авалтын журам зөрчиж худалдан авсан.

Булган сумын Орон нутгийн хөгжлийн сан 44.0 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг зөрчсөн.

Цэнгэл сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 8 дугаар багт худаг гаргах 20.0 сая төгрөгийн, дунд гудамжны дэнжид худаг гаргах 20.0 сая төгрөгийн, 9 дүгээр багт гүний худаг гаргах 20.0 сая төгрөгийн нийтдээ 60.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлуудыг босго үнэд багтаах зорилгоор төсөвт өртгийг хувааж гэрээ шууд байгуулах замаар гүйцэтгүүлсэн.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл

Аймгийн Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө 9,432.5 сая төгрөг, гүйцэтгэл 8,144.4 сая төгрөг байна.

Орон нутгийн төсвөөс 7,963.2 сая төгрөгийн санхүүжилт авч туслах үйл ажиллагааны орлогоос 183.1 сая төгрөг оруулж, төсөвт 1.9 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлж, нийт 8,144.4 сая төгрөгийн эх үүсвэрээр үйл ажиллагаа явуулсан байна.

Орон нутгийн төсвөөс авах санхүүжилтийг 1,309.5 сая төгрөгөөр дутуу авсантай холбоотой оны эцэст аймгийн 2024 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл, арга хэмжээний үлдэгдэл санхүүжилт 599.0 сая төгрөг, аймгийн 2024 оны боловсрол, эрүүл мэнд, соёлын салбарын засварын

хөрөнгийн үлдэгдэл санхүүжилт 247.9 сая төгрөг, нийт 846.9 сая төгрөгийг өглөгөөр бүртгэж тайлагнасан байна.

Боловсрол, эрүүл мэнд, соёлын салбарын их засварын хөрөнгө оруулалтын ажлуудаас:

- Баяннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн хуучин гал тогооны байрыг хөвгүүдийн байр болгон засварлах 20.0 сая төгрөгийн их засварын ажил хэрэгжээгүй ба 2025 онд дахин төлөвлөгдсөн байна.
- Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн дотуур байрны засвар, Алтанцөгц сумын Соёлын төвийн засвар, Баяннуур сумын Ахуйн үйлчилгээний барилгыг цэцэрлэгийн зориулалттай болгож засварлах ажлуудын засвар дуусаагүй, Буянт сумын цэцэрлэгийн засвар дууссан боловч улсын комисс ашиглалтад хүлээж аваагүй байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтын ажлуудаас:

- Аймгийн Төв талбайн усан оргилуурын засвар, Өлгий сумын 13 дугаар цэцэрлэгийн засвар, Бугат сумын гэрэлтүүлгийн засварын ажлууд болон Баяннуур сумын 2 багийн салбар цэцэрлэгийн хатуу эдлэл худалдан авах ажил, Дулааны 2 дахь эх үүсвэр болон түүний гадна шугам сүлжээний ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах ажлууд огт хэрэгжээгүй байна.
- Толбо сумын Ерөнхий боловсролын сургуульд ухаалаг дэлгэц, шалгалтын тест шалгах төхөөрөмж худалдан авах ажил болон мотоцикл худалдан авах ажлын гэрээнүүд хийгдсэн боловч гүйцэтгэлээ ирүүлээгүй байна.

Замын сангийн гүйцэтгэл

Замын сангийн 2024 оны батлагдсан төсөв 1,600.1 сая төгрөг ба үүний 1,363.9 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 236.2 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөсөн. Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,263.9 сая төгрөгийн санхүүжилт авч урьд оны үлдэгдлээс 161.9 сая төгрөг, нийт 1,425.7 сая төгрөгийг зарцуулж оны эцэст 70.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Ногооннуур сумын Улаан чулуут багийн Хатуугийн замын засварын болон Баяннуур сумын 2 дугаар багийн Заагтын хавцлын замын засварын ажлууд хэрэгжээгүй байна.

ТЕЗ-ийн харьяа орон нутгийн төсвийн байгууллагуудаас ерөнхий чиглэлийн дагуу авсан судалгаануудын дүн

А. Худалдан авах ажиллагааны судалгаа

Орон нутгийн төсвийн байгууллагуудын 83 хувь нь худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлж ажилаагүй байна.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа 36 төсөвт байгууллагаас ирүүлсэн худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн судалгааны дүнгээс харахад 6 байгууллага худалдан авах ажиллагааг хэрэгжүүлсэн, бусад 30 байгууллага бараа, ажил үйлчилгээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт №17 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

сая төгрөгөөр

ТӨЗ	Харьяа төсөвт байгууллагын тоо	Худалдан авах ажиллагааг хэрэгжүүлсэн байгууллагын тоо	Нийт худалдан авалт	Үүнээс			
				Нээлттэй тендер шалгаруулалт		Гэрээ шууд байгуулах арга	
				Тоо	Төсөвт өртөг	Тоо	Төсөвт өртөг
Аймгийн Засаг дарга	36	6	34	2	132.7	32	396.3

Эх сурвалж: Ерөнхий чиглэлийн судалгааны нэгтгэлээс

Аймгийн Засаг даргын тамгын газар ТБОНӨХБААХАТХ-д заасны дагуу тухайн жилд худалдан авах 132.7 сая төгрөгийн 2 бараа, ажил, үйлчилгээ буюу тээвэр, шатахуун, бичиг хэрэг нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер зарлаж хэрэгжилтийг хангаж ажилласан байна. Оны эхэнд анх баталсан төсвийн дүнгээр тендер зарласан боловч оны эцэст гүйцэтгэлээр тээвэр, шатахуун нийлүүлэх ажлын гүйцэтгэл тендер шалгаруулалтын дүнгээр байгуулсан гэрээний дүнгээс 38.4 сая төгрөгөөр хэтэрсэн дүнтэй байна.

Өлгий сумын ЗДТГ 308.4 сая төгрөгийн 1.2-45.8 сая төгрөгийн бараа, ажил үйлчилгээнд 28 шууд гэрээ байгуулж /45.8 сая төгрөгийн шууд гэрээ нь халаалтын гэрээ/, Булган сумын ЗДТГ 10.1 сая төгрөгийн бараа үйлчилгээг, Цагааннуур тосгоны захирагчийн алба 50.0 сая төгрөгийн бараа, ажил үйлчилгээг, Орон нутгийн өмчийн газар 13.0 сая төгрөгийн хөрөнгийг, Байгаль орчин, аялал, жуулчлалын газар 14.9 сая төгрөгийн бараа, ажил үйлчилгээг тус тус шууд гэрээ байгуулж худалдан авсан байна.

Б. Төсвөөс 2024 онд зарцуулсан бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж /210801/-ийн судалгаа

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлын гүйцэтгэлтэй холбоотой 60.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа 36 төсөвт байгууллагаас 33 байгууллагын бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн дансаар тайлант онд 561.1 сая төгрөгийн зардал гарсан байна.

Тухайн дансаар байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой зардлууд, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардал, гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний зардал, ангилагдаагүй бусад зориулалт, арга хэмжээний зардал, харуул хамгаалалтын зардлуудтай холбоотой гүйлгээ хийгдсэн байна.

Хүснэгт №18 БГБНАУТХ-ийн зардлын судалгаа сая төгрөгөөр

ТЭЗ	Харьяа төсөвт байгууллагын тоо	210801 дансаар зардал гараагүй байгууллагын тоо	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал гарсан		Зөрчил илэрсэн байгууллагын тоо		Зөвлөмжийн тоо	Албан шаардлагын тоо
			Байгууллагын тоо	Мөнгөн дүн	Байгууллагын тоо	Мөнгөн дүн		
Аймгийн Засаг дарга	36	3	33	564.1	4	60.5	2	2

Эх сурвалж: Ерөнхий чиглэлийн судалгааны нэгтгэлээс

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн дансаар гарсан ажил гүйлгээнүүдтэй холбоотой 4 байгууллагад 60.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээний зардалд анхан шатны бүрдэл дутуу баримтаар 3 удаагийн гүйлгээгээр 8.3 сая төгрөгийн зардал гаргасан, сумын орон нутгийн орлогын давсан хэсгээс байгаль хамгаалах санд хуваарилсан хөрөнгөнөөс ан амьтны тоо толгойн судалгаа хийх гэрээний урьдчилгаанд “Агнуур судлалын нийгэмлэг”-т 10.0 сая шилжүүлсэн боловч үр дүнг тооцоогүй зөрчлүүдэд зөрчил арилгуулахаар 2 байгууллагад зөвлөмж өгөгдсөн.

Худалдан авах ажиллагааг төлөвлөж ажиллаагүй, тоног төхөөрөмж худалдан авахдаа цахим худалдан авалтын журмыг зөрчсөн, худалдан авах ажиллагааг төлөвлөж ажиллаагүй, 15.1 сая төгрөгийн тоног төхөөрөмж, эд хогшлыг худалдан авахдаа цахим худалдан авалтын журмыг зөрчсөн зөрчлийн дүнгээр 2 байгууллагад албан шаардлага өгөгдсөн байна.

В. Төсвөөс 2024 онд зарцуулсан бараа үйлчилгээний бусад зардал /210901/-ын судалгаа

Бараа үйлчилгээний бусад зардлын гүйцэтгэлтэй холбоотой 209.6 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа 36 төсөвт байгууллагаас 28 байгууллагын бусад бараа үйлчилгээний зардлын дансаар 2024 онд 11,005.9 сая төгрөгийн зардал гарсан байна.

Хүснэгт №19 Бараа үйлчилгээний бусад зардлын судалгаа сая төгрөгөөр

ТЭЗ	Харьяа төсөвт байгууллагын тоо	210901 дансаар зардал гарсан байгууллагын тоо	Мөнгөн дүн	Зөрчил илэрсэн байгууллагын тоо		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
				Байгууллагын тоо	Мөнгөн дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

Аймгийн Засаг дарга	36	28	11,005.9	6	209.6	1	19.6	6	146.5	2	43.6
---------------------	----	----	----------	---	-------	---	------	---	-------	---	------

Эх сурвалж: Ерөнхий чиглэлийн судалгааны нэгтгэлээс

Бараа үйлчилгээний бусад зардлын дансны зарцуулалттай холбоотой 6 байгууллагад 209.6 сая төгрөгийн зөрчил илэрч 19.1 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 146.5 сая төгрөгийн зөрчилд 6 албан шаардлага, 43.6 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн байна.

Г. Аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын 2024 оны орон тооны судалгаа

Орон нутгийн төсвийн байгууллагуудын нийт албан хаагчдын 41.2 хувийг төрийн захиргааны албан хаагчид эзэлж байна.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудын 2024 оны орон тооны батлагдсан төлөвлөгөө 683, гүйцэтгэл 684 байна. Харьяа 36 байгууллагын цалингийн зардлын батлагдсан төсөв 21,390.9 сая төгрөг, гүйцэтгэл 20,598.9 сая төгрөг байна.

Хүснэгт №20 ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын орон тоо, цалингийн судалгаа сая төгрөгөөр

ТЕЗ	Харьяа төсөвт байгууллагын тоо	Цалингийн зардал		Орон тоо	
		Төл	Гүй	Төл	Гүй
Аймгийн Засаг дарга	36	20,350.4	19,579.5	683	684

Эх сурвалж: Ерөнхий чиглэлийн судалгааны нэгтгэлээс

Аймгийн ТЕЗ-ийн харьяа төсөвт байгууллагуудын удирдах албан тушаалд 170, гүйцэтгэх орон тоонд 323, үйлчлэх орон тоонд 191 хүн ажилласан байна. Гүйцэтгэх орон тооны гүйцэтгэл 8 орон тоогоор дутуу, үйлчлэх орон тооны гүйцэтгэл 1, гэрээтийн орон тооны гүйцэтгэл 9 орон тоогоор илүү байна.

Аймгийн ТЕЗ-ийн харьяа төсөвт байгууллагуудад төрийн захиргааны 282, төрийн тусгай 5, төрийн үйлчилгээний 262, улс төрийн 135 албан хаагч ажиллаж байна. Төрийн захиргааны орон тооны гүйцэтгэл 1 орон тоогоор дутуу, төрийн үйлчилгээний орон тоо 1, улс төрийн албан хаагчийн орон тоо 1 орон тоогоор тус тус төлөвлөснөөс илүү байна.

Нэмэлт санхүүжилтийн зарцуулалт

Нэмэлт санхүүжилтийн дансны зардлын 90.6 хувийг усан цахилгаан станцын нөхөн олговор эзэлж байна.

Аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын нэмэлт санхүүжилтийн данс оны эхэнд 2.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба тайлант онд ЗГНХ, ЗДНХ, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс 8,091.8 сая төгрөгийн, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс 437.8 сая төгрөгийн, төсвийн

байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлогоос 292.9 сая төгрөгийн, нийт 8,822.5 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийн орлого хүлээн авч үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Урсгал зардалд 8,817.6 сая төгрөгийг, хөрөнгийн зардалд 7.5 сая төгрөгийг зарцуулж төсөвт 58.9 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Урсгал зардлын 97.5 хувийг буюу 8,600.5 сая төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардлын 210901 дансны зарцуулалт эзэлж байна. Үүний 7,995.7 сая төгрөг нь аймгийн ЗДТГ-ын дансаар Засгийн газрын нөөц хөрөнгөөс хуваарилсан Баяннуур сумын иргэдэд олгосон Эрдэнэбүрэн усан цахилгаан станцын нөхөн олговрын зарцуулалт байна.

БҮЛЭГ 3. ХӨТӨЛБӨР, ХҮРЭХ ҮР ДҮН, ЗОРИЛТОТ ТҮВШНИЙ ХЭРЭГЖИЛТ

3.1 ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүн, зорилтот түвшин

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн, хүрэх үр дүн, зорилтот түвшин 94 хувийн гүйцэтгэлтэй байна.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 онд хэрэгжүүлэх 16 хөтөлбөрийн хүрэх үр дүн, чанарын болон тоон үзүүлэлтийг 26 шалгуур үзүүлэлтээр Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.4-д заасны дагуу аймгийн ИТХ-ын 2023 оны “Баян-Өлгий аймгийн 2024 оны төсөв батлах тухай” 221 дүгээр тогтоолоор баталсан байна.

Орон нутгийн өөрийн удирдлага хөтөлбөр буюу аймгийн ИТХ-ын үйл ажиллагаанд хамаарах 2 хөтөлбөр, орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөрт хамаарах аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 14 хөтөлбөрийг баталсан байна.

Аймгийн ТЕЗ-ийн Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн 2 үзүүлэлтийн 4 шалгуур үзүүлэлтээр үр дүнг тооцохоор төлөвлөж, 96.5 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Аймгийн ИТХ-ын орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа хөтөлбөрийн хүрэх үр дүнг 2 шалгуур үзүүлэлтээр дүгнэсэн ба зорилтот түвшний биелэлт 101.7 хувьтай гарсан байна. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн хүрэх үр дүнг 1 шалгуур үзүүлэлтээр төлөвлөсөн ба зорилтот түвшний биелэлт 100 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага хөтөлбөрийн хүрэх үр дүн 101.7 хувийн, Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх, орон нутгийн хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа, ойжуулалт, хот байгуулалт, тохижилт, нийгмийн хөтөлбөрүүдийн хүрэх үр дүн, зорилтот түвшний биелэлт 100 хувийн гүйцэтгэлтэй байна.

Боловсрол, Эрүүл мэнд, Соёлын байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хангах хөтөлбөрийн хүрэх үр дүн, зорилтот түвшний гүйцэтгэл 98 хувийн гүйцэтгэлтэй байна.

Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага, үйл ажиллагаа хөтөлбөрийн Хоршоо хөгжүүлэх сангийн зарцуулалтын хүрэх үр дүн, зорилтот түвшний гүйцэтгэл 93.8 хувийн гүйцэтгэлтэй гэж дүгнэсэн байна.

Худалдан авах ажиллагаа хөтөлбөрийн хүрэх үр дүн, зорилтот түвшний гүйцэтгэл 90 хувийн, орон нутгийн хөгжлийн сангийн хэрэгжилтийн хүрэх үр дүн, зорилтот түвшний гүйцэтгэл 80 хувийн, орон нутгийн хөрөнгө оруулалтын хүрэх үр дүн, зорилтот түвшний гүйцэтгэл 91.9 хувийн, автозам хөтөлбөрийн хүрэх үр дүн, зорилтот түвшний биелэлт 82 хувийн, орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага, үйл ажиллагааны Засаг даргын ерөнхий дансаар дамжуулан хэрэгжүүлэх арга хэмжээний хүрэх үр дүн, зорилтот түвшний биелэлт 62.5 хувийн гүйцэтгэлтэй байна.

БҮЛЭГ 4. ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬ, ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

4.1 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Санхүүгийн тайлангийн аудитаар байгууллагуудын Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд горим сорил хэрэгжүүлж шалгасан.

Аймгийн Засаг даргын харьяа төсөвт байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 19 байгууллагад 951.8 сая төгрөгийн зөрчил илэрч 658.5 сая төгрөгийн зөрчилд 8 албан шаардлага, 293.9 сая төгрөгийн зөрчилд 11 заалт бүхий зөвлөмж өгсөн байна.

4.2 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил давтагдан гарч байна.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа 14 төсвийн төвлөрүүлэн захирагч, 37 орон нутгийн төсөвт байгууллага, 29 орон нутгийн тусгай сан, орон нутгийн өмчийн 3 аж ахуйн нэгж, 3.1.5-т хамаарах төсвөөс санхүүжилт авдаг 4 өрхийн эмнэлэг, нийт 87 төсвийн байгууллага, аж ахуйн нэгж шилэн дансны нэгдсэн цахим системд хамрагдаж, мэдээллээ байршуулсан байна.

Аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад нийт 3,591.3 сая төгрөгийн зөрчил илэрч 2 байгууллагад 135.2 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 15 байгууллагад 3,417.9 сая төгрөгийн зөрчилд 15 заалт бүхий зөвлөмж өгч, өмнөх оны аудитаар Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой илэрсэн зөрчлийг давтан гаргасан 1 байгууллагын 38.2 сая төгрөгийн зөрчилд хариуцлага тооцуулах 1 албан шаардлага хүргүүлсэн.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил жил бүр давтагдан гарч байгаа нь аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд дотоод хяналт хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны хяналт сул байгаатай холбоотой байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

1. Татварын болон татварын бус орлогын төлөвлөгөөг үндэслэл муутай төлөвлөснөөс орон нутгийн төсвийн суурь орлогын төлөвлөгөө 3,362.6 сая төгрөгөөр тасарсан байна.
2. Орон нутгийн төсвийн зарлагын гүйцэтгэл 87.6 хувьтай гарсан нь төсвийн төлөвлөлт, хэрэгжилттэй холбоотой байна.
3. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагийн төрийн албан хаагч нарт олгосон орон нутгийн 30 хувийн нэмэгдлийг төсвийн орлого бүрдүүлэлттэй уялдуулж төлөвлөж, хэрэгжүүлээгүй байна.
4. Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүн, зорилтот түвшин 94 хувийн гүйцэтгэлтэй байна.
5. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.

Аймгийн ТЕЗ-ийн анхааралд толилуулах нь:

Аудитаар Баян-Өлгий аймгийн 2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгасан 80,779.0 сая төгрөгийн санхүүжих эх үүсвэр, 70,758.5 сая төгрөгийн зарлагын гүйцэтгэлийг баталгаажуулав.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтнуудад дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

I. АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА-Д:

1. Орон нутгийн татварын болон татварын бус орлогын төлөвлөгөөг үндэслэлтэй төлөвлөж батлахад анхаарах;
2. Төсвийн жилийн дундуур Орон нутгийн хөгжлийн сан, орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнүүдийн төсвийг нэмэгдүүлж тодотгож байгаа боловч хэрэгжилт нь хангалтгүй байгаа асуудалд анхаарах;

II. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА-Д:

1. Төсвийн зарлагын санхүүжүүлэх эх үүсвэрийг нөхөх зорилгоор татварын болон татварын бус орлогыг үндэслэлгүй төлөвлөсөн асуудлыг дараа оны төсвийн төлөвлөлтийг боловсруулахдаа анхаарч төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулах;
2. Төсвийн жилийн дундуур хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийн төсвийг тодотголоор нэмэгдүүлж өөрчлөлт оруулахгүй байх;
3. Аймгийн Засаг даргын ерөнхий дансаар хөрөнгө оруулалтын болон урсгал зардалд их хэмжээний хөрөнгө төлөвлөж, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулахгүй байх;
4. Төсвийн байгууллагуудын худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу төлөвлөж хэрэгжүүлээгүй байгаа асуудалд анхаарч, хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж ажиллах;



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2025 оны 04 сарын 21 өдөр

Дугаар А/10

Өлгий

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4, 29 дүгээр зүйлийн 29.4 дэхь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын хавсралтын 18 дугаар хэсгийн 18.9, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны “Эрх шилжүүлэх тухай” А/102 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтын 1-ийн 1.1, 1.4 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1.Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, 2024 оны жилийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг хавсралтаар баталгаажуулсугай.

2.Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргад хүргүүлсүгэй.

3.Аудитын ажлын болон нотлох баримтыг ажлын 7 хоногийн дотор архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэн өгөхийг аудитын баг хариуцсан ахлах аудитор (Д.Назгүл)-д үүрэг болгосугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Х.Женисбек)-т даалгасугай.



Ж.АЙГҮЛ

ХАВСРАЛТ:

Хавсралт №1

Аймгийн ТЕЗ-ийн 2024 оны аудит хийсэн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

сая төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	80,779.0	70,758.5	87.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	56,340.6	50,974.9	90.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	54,325.3	49,102.7	90.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	20,350.4	19,579.5	96.2
210101	Үндсэн цалин	10,995.3	10,669.2	97.0
210102	Нэмэгдэл	7,659.4	7,441.1	97.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	367.5	348.6	94.9
210104	Урамшуулал	1,186.4	977.8	82.4
210105	Гэрээт ажлын хөлс	141.9	142.7	100.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,527.2	2,491.5	98.6
210201	Тэтгэврийн даатгал	1,712.4	1,687.7	98.6
210202	Тэтгэмжийн даатгал	207.4	204.2	98.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	101.3	100.2	98.9
210204	Ажилгүйдлийн даатгал	101.2	99.7	98.6
210205	Эрүүл мэндийн даатгал	404.9	399.6	98.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,186.7	13,686.0	90.1
210301	Гэрэл, цахилгаан	948.7	932.9	98.3
210302	Түлш, халаалт	12,779.6	11,367.1	88.9
210303	Цэвэр, бохир ус	864.3	799.8	92.5
210304	Байрны түрээс	594.1	586.1	98.7
2104	Хангамж, бараа материалын зардал	1,025.3	974.8	95.1
210401	Бичиг хэрэг	132.9	127.7	96.1
210402	Тээвэр, шатахуун	742.2	722.5	97.3
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	113.1	94.3	83.4
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	9.0	6.1	67.2
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	28.0	24.2	86.4
2105	Нормативт зардал	318.9	314.2	98.5
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	206.4	206.4	100.0
210502	Хоол, хүнс	69.9	69.9	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	42.6	37.9	89.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	693.8	594.9	85.7
210601	Багаж, техник, хэрэгсэл	176.2	164.9	93.6
210602	Тавилга	28.3	8.4	29.6
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2.0	1.5	74.6
210604	Урсгал засвар	487.4	420.1	86.2

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2024 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

2107	Томилолт, зочны зардал	337.1	291.8	86.6
210702	Дотоод албан томилолт	318.9	282.2	88.5
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	18.2	9.6	52.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,961.3	2,674.5	90.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,903.6	2,636.8	90.8
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	9.7	2.6	26.4
210803	Даатгалын үйлчилгээ	9.3	8.2	88.2
210804	Тээврийн хэрэгслийн татвар	6.6	4.6	69.5
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	2.0	1.1	55.1
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	23.3	17.2	73.6
210807	Газрын төлбөр	4.6	3.4	74.4
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0.1	0.1	44.1
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2.1	0.7	33.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,924.5	8,495.5	161.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,789.0	8,381.7	77.7
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	135.6	113.8	84.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,015.3	1,872.2	92.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,015.3	1,872.2	92.9
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	196.0	151.7	77.4
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	108.1	108.1	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	531.6	538.1	101.2
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,132.2	1,038.4	91.7
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	47.3	35.9	75.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	24,324.8	19,783.6	81.3
2200	Дотоод эх үүсвэрээр	24,324.8	19,783.6	81.3
220001	Барилга байгууламж	4,088.9	3,048.8	74.6
221001	Их засвар	3,682.2	2,720.3	73.9
222001	Тоног төхөөрөмж	1,307.5	1,030.2	78.8
223001	Бусад хөрөнгө	15,246.3	12,984.4	85.2
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	113.6	-	-
230001	Эргэж төлөгдөх зээл	113.6	-	-
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	80,779.0	71,333.4	88.3
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	73,980.3	69,894.7	94.5
132001	Орон нутгийн төсвөөс	62,030.8	58,427.7	94.2
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	11,949.5	11,467.1	96.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	6,798.7	1,438.6	21.2
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,724.1	1,240.2	71.9
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	198.4	-
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	5,074.6	-	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		4,118.4	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		4,693.3	

6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ			
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	40.0	40.0	
610001	Төсвийн байгууллага	40.0	40.0	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	683.0	684.0	100.1
620001	Удирдах ажилтан	171.0	170.0	99.4
620002	Гүйцэтгэх ажилтан	329.0	323.0	98.2
620003	Үйлчлэх ажилтан	110.0	122.0	110.9
620004	Гэрээт ажилтан	73.0	69.0	94.5
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	683.0	684.0	100.1
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	279.0	274.0	98.2
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	4.0	4.0	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	207.0	217.0	104.8
650010	Гэрээт ажилтан	52.0	48.0	92.3
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	141.0	141.0	100.0

Эх сурвалж: Аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хавсралт №2

Баян-Өлгий аймгийн ТЕЗ-ийн 2024 оны нэмэлт санхүүжилтийн гүйцэтгэл

сая төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,825.01
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,817.56
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,757.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	62.75
210101	Үндсэн цалин	61.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.47
210104	Урамшуулал	1.13
210105	Гэрээт ажлын хөлс	0.14
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7.11
210301	Гэрэл, цахилгаан	5.80
210302	Түлш, халаалт	1.31
2104	Хангамж, бараа материалын зардал	55.62
210401	Бичиг хэрэг	0.72
210402	Тээвэр, шатахуун	50.67
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4.23
2105	Нормативт зардал	1.37
210502	Хоол, хүнс	1.37
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15.50
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.34
210604	Урсгал засвар	15.16
2107	Томилолт, зочны зардал	12.98
210702	Дотоод албан томилолт	12.98
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2.12
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1.75
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0.07
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.31
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,600.52
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,600.52
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.60
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.60
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.60
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	59.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	59.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7.45
2200	Дотоод эх үүсвэрээр	7.45
225001	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	7.45

II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	8,822.51
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,822.51
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,091.82
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	437.80
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	292.89
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	(2.50)
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2.50
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

Эх сурвалж: Аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан